ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2021)

ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2017 он

Хэвлэлтэд бэлтгэсэн:
С.БАТЦЭЦЭГ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны мэргэжилтэн

Хянан тохиолдуулсан:
С.ТУНГАЛАГТАМИР, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга
Т.ЭНХБАЯР, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга

Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хамтран Япон улсын Ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа" техникийн туслалцааны төслийн хүрээнд хэвлэв.

"Xpress" хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ГАРЧИГ

МЭНДЧИЛГЭЭ 4

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.1. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ 7

1.2. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ 25

1.3. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 26

1.4. ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 27

1.5. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 28

1.6. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 29

ХОЁРДУГААР ХЭСЭГ: МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2.1. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР 31

2.2. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2021) 45

2.3. ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН 59

ГУРАВДУГААР ХЭСЭГ: НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

3.1. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ, НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ 63

3.2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН МОНГОЛ УЛСЫН ЭЭЛЖИТ НАЙМ БА ЕСДҮГЭЭР ИЛТГЭЛИЙН ТАЛААРХ АЖИГЛАЛТЫН ДҮГНЭЛТҮҮД 78



МЭНДЧИЛГЭЭ

Хөгжлийн төлөө тэмүүлэх аянд бид нэг баг болж гарсан бөгөөд зорьсон газраа хүрэхийн тулд хүн бүрийн оролцоог тэгш хангаж, хөгжлийн үр шимээс тэгш хүртээх хариуцлагатай үүргийг ард түмнийхээ өмнө хүлээсэн билээ.

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгод “Жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх”, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д “Нийгмийн хөгжил, дэвшилд жендэрийн тэгш оролцоог хангах замаар нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэж тусгасан.

Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг батлаад байна. Тус хөтөлбөр батлагдсанаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, жендэрийн талаарх дэлхий дахины чиг хандлагад нийцүүлэх, олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэх чухал алхам болсон гэдгийг онцлон тэмдэглэе.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг сайжруулах, гэр бүлийн эрүүл, зөв зан үйл, ёс суртахууны чиг хандлагыг төлөвшүүлэх, тэгш хүртээмжтэй ногоон ажлын байр бий болгох, эрэгтэйчүүдэд тусгайлан тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет бүх аймаг, дүүрэгт бий болгох, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр бодит үр дүн гарах юм.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь улс орны хөгжил дэвшлийн үндэс суурь бөгөөд хүний хөгжил, тэр дундаа эмэгтэй, эрэгтэйчүүдийг эн тэнцүү хөгжүүлэх бодлогын хүрээнд батлагдсан энэхүү хөтөлбөр нь Монгол хүн эх орондоо амар амгалан, эрүүл энх, аз жаргалтай амьдрах, хөгжин дэвшихэд нэн чухал дэмжлэг болох учиртай.

Цаашид, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодит үр дүнг гаргахад төр, төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийт, олон улсын байгууллагын хамтын идэвх санаачилга, өргөн оролцоо туйлын чухал юм.

Хүн бүрт тэгш эрх, тэгш боломжийг бий болгохын төлөө жендэрт суурилсан хөгжлийн бодлогыг тодорхойлсон, түмэнд ээлтэй төрийг төлөвшүүлэхэд хүчин чармайлтаа нэгтгэцгээе.

Монгол Улсын Ерөнхий сайд,

Жендэрийн үндэсний хорооны дарга  Ж.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж

2.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актын хэм хэмжээ нь энэ хуулиар баталгаажуулсан жендэрийн эрх тэгш байдлыг хангах хэм хэмжээг дордуулахыг хориглоно.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын иргэн,

Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, гадаадын

аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;

4.1.2.“жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;

4.1.3.“жендэрийн хэвшмэл үзэл” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг;

4.1.4.“жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.5.“жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт” гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг;

4.1.6.“жендэрийн шууд бус ялгаварлан гадуурхалт” гэж хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг;

4.1.7.“бэлгийн дарамт” гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.8.“жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.9.“хүйсийн төлөөллийн доод хязгаар (квот)” гэж удирдах албан

тушаал дахь эрэгтэй, эмэгтэй хүний төлөөллийн доод хувь хэмжээг.

5 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого

5.1.Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана:

5.1.1.жендэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах;

5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;

5.1.3.төрийн хариуцлагын зарчим: төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх;

5.1.4.жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим: хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох;

5.1.5.жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.

5.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэнэ.

6 дугаар зүйл. Жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох

6.1.Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно.

6.2.Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн дарамт нь жендэрийн ялгаварлан гадуурхалтад хамаарна.

6.3.Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах, эрхийг нь хамгаалах нөхцөл, журмыг хуулиар тогтооно.

6.4.Жендэрийн ялгаварлан гадуурхалт нь энэ хуулийн 4.1.5, 4.1.6-д заасан шууд ба шууд бус хэлбэртэй байна:

6.5.Дараахь үйл ажиллагаа жендэрийн ялгаварлан гадуурхалтад үл хамаарна:

6.5.1.зөвхөн нэг хүйсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэнд, боловсролын зэрэг төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх;

6.5.2.оюутан, сурагчдын дотуур байр, эмнэлэг, асрамжийн байгууллага, амралт, сувилал, хорих газар болон түр саатуулах байр, эрүүлжүүлэх байранд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүйсээр ялган байрлуулах;

6.5.3.орон сууц түрээслэх буюу хамтран хөлслөхөд зөвхөн аль нэг хүйсийн хүнийг сонгох;

6.5.4.аль нэг хүйсийн гишүүнчлэл бүхий төрийн бус байгууллага байгуулах;

6.5.5.нэг хүйсийн хүмүүсийг хамруулсан урлаг, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах;

6.5.6.Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1 дэх заалтыг хэрэгжүүлэх болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага зэрэг байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч нэг хүйсийн хүнийг сонгох.

7 дугаар зүйл. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах тусгай арга хэмжээ

7.1.Энэ хуулийн 5.2-т заасан төрийн бодлогын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм, гэр бүлийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгах, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх бөгөөд эдгээр тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан тусгай арга хэмжээг дараахь хүрээнд явуулна:

7.2.1.эх, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр батлах;

7.2.2.улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх;

7.2.3.тодорхой салбар дахь хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ авах, эсхүл аль нэг ажил, мэргэжлийн хүйсийн тэгш бус төлөөллийг тэнцвэржүүлэхэд түлхэц өгөхүйц хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, эсхүл тэтгэлэг тогтоох;

7.2.4.энэ хуулийн 6.5.6-г үндэслэн сургалтын байгууллагын элсэлтийн нөхцөл, шаардлагыг хүйсээс хамааран ялгаатай тогтоох.

7.3.Энэ хуулийн 7.2.1-д зааснаас бусад тусгай арга хэмжээг тэгш боломж, тэгш байдал тогтоох зорилго биелэгдмэгц зогсооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ХҮРЭЭНД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ БАТАЛГАА

8 дугаар зүйл. Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

8.1.Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.

8.2.Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.

8.3.Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна.

8.4.Улс төрийн нам нь энэ хуулийн 8.2, 8.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийн тайланг энэ хуулийн 18.1-д заасан Жендэрийн үндэсний хороонд хоёр жил тутам хүргүүлж байна.

9 дүгээр зүйл. Эдийн засгийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

9.1.Иргэн бүр хүйсээс үл хамааран аж ахуйн нэгж байгуулах, бүртгүүлэх, аж ахуйн ба мэргэжил, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх тэгш эрхтэй байна.

9.2.Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь газар, бусад үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө, төсвийн хөрөнгө, санхүүгийн актив, санхүүгийн зээл болон эдийн засгийн бусад нөөц баялгийг эрэгтэй, эмэгтэй хүнд адил нөхцөлөөр тэгш, хүртээмжтэй хуваарилах үүрэг хүлээнэ.

9.3.Иргэний хуулиар зохицуулсан иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх эдийн ба эдийн бус баялагтай холбоотой харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

9.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах болон төрөөс үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээнд жендэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

10 дугаар зүйл. Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

10.1.Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараахь бодлого хэрэгжүүлнэ:

10.1.1.томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх;

10.1.2.төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;

10.1.3.зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх;

/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар "хилийн" гэсний дараа "ба дотоодын" гэж нэмсэн бөгөөд 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

10.1.4.төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах бодлого, арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.

10.2.Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс (цаашид "хороо" гэх) зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна.

10.3.Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.

10.4.Энэ хуулийн 11.1-11.9 дэх хэсгийн заалт төрийн байгууллага, албан тушаалтанд нэгэн адил хамаарна.

11 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

11.1.Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах ба Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглоно.

11.2.Талууд хамтын гэрээ, хэлэлцээрт эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, мэргэжлийн эрх ашиг, гэр бүлийн үүргээ хослуулах, хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах, түүнчлэн ижил ажилд адил цалин, нэмэгдэл хөлс тогтоох, ижил нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгана.

11.3.Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дараахь үүрэг хүлээнэ:

11.3.1.жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар ажилтнуудад мэдээлж байх;

11.3.2.энэ хуулийн 6.5 дахь хэсэг болон 7 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд ажлын байрны сул орон тооны зар мэдээнд хүйсийг онцлон дурдахгүй, эсхүл аль нэг хүйсийг давуу гэж үзсэн агуулгыг тусгахгүй байх;

11.3.3.иргэнийг ажилд авахдаа тухайн байгууллага болон түүний бүтцийн нэгж дэх хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг харгалзан цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох;

11.3.4.адил хөдөлмөр буюу адил чанарын ажил эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил тэгш цалин хөлс олгох, ижил нөхцөл тогтоохтой холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

11.3.5.эрэгтэй, эмэгтэй ажилтныг албан тушаал дэвшүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, мэргэшлийн ур чадварыг ахиулах, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд хүний нөөцийн бүртгэлд үндэслэдэг байх;

11.3.6.сул орон тоо, мэргэжлийн сургалт, мэргэшүүлэх сургалтын тухай мэдээллийг нийт ажилтанд тухай бүр хүргэж байх;

11.3.7.мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтын дүнгээр ажилд орж чадаагүй иргэний хүсэлтээр тухайн шалгалт, сонгон шалгаруулалтаар эсрэг хүйсийн хүнийг ажилд авсан үндэслэлийг бичгээр гаргаж өгөх;

11.3.8.бүтцийн өөрчлөлтийн улмаас нийт ажилтны гуравны нэгээс доошгүйг

чөлөөлөх тохиолдолд чөлөөлөгдөх ажилтнуудын хүйсийн харьцааг ажилласан хугацаанаас нь үл хамааран нийт ажилтны хүйсийн харьцаатай адил тогтоох;

11.3.9.хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөж чадахуйц түвшинд байлгах зорилгоор тэднийг давтан сургалтад хамруулах;

11.3.10.аж ахуйн нэгж, байгууллага нь хүйсийн тэнцвэртэй байдлын тухай тайлангаа жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.

11.4.Ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар дараахь арга хэмжээ авна:

11.4.1.хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах;

11.4.2.бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх.

11.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ажилтан дараахь эрхтэй:

11.5.1.жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтын талаар ойлголт, мэдээлэл авах, сургалтад хамрагдах;

11.5.2.жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтад өртсөн тухай өөрөө буюу хохирогчийн өмнөөс гомдол гаргах, тайлбар өгөх;

11.5.3.Хөдөлмөрийн тухай хуулийн 7.2, 7.4-т заасан хориглосон үйлдэл гарсан тохиолдолд уг зөрчлийн талаар ажил олгогчид мэдэгдэж, зөрчигчид хариуцлага хүлээлгэх, хохирлыг арилгах арга хэмжээ авахыг шаардах.

11.6.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ажилтан дараахь үүрэгтэй:

11.6.1.байгууллагын бусад ажилтан болон харилцагч, үйлчлүүлэгчид бэлгийн дарамт үзүүлэхгүй байх;

11.6.2.жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон бусад хэм хэмжээг сахин биелүүлэх.

11.7.Хөдөлмөрийн тухай хуулийн 130.2-т заасны дагуу хөдөлмөрийн дотоод журамд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тусгана.

11.8.Мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтын дүнгээр ажилд орж чадаагүй иргэн тухайн шалгалт, сонгон шалгаруулалтаар ажилд орсон эсрэг хүйсийн хүний боловсрол, мэргэжил, ажлын дадлага, туршлага болон бусад шалгуурын талаар ажил олгогчоос бичгээр тайлбар өгөхийг шаардах эрхтэй.

11.9.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажил олгогчийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

12 дугаар зүйл. Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

12.1.Эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна.

12.2.Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн ажлын байр, сургалтын орчныг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгаж, жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.

12.3.Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг тусгах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна.

12.4.Сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын стандарт, зохих түвшний сургалтын хөтөлбөрт суралцагчийн зайлшгүй эзэмшвэл зохих жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой агуулга, арга зүй, үнэлгээг тусгана.

12.5.Ерөнхий боловсролын сургууль, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно.

12.6.Насанд хүрсэн иргэн нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний зөрүүг багасгахад чиглэсэн боловсрол нөхөн олгох албан ба албан бус сургалтад хамрагдах, тасралтгүй боловсролын үйлчилгээг хүртэх тэгш боломж, нөхцөлөөр хангагдана.

12.7.Энэ хуулийн 6.5.1, 6.5.6-д зааснаас бусад боловсролын бүх шатны сургалтын байгууллага элсэлтийн нөхцөл, шаардлагыг хүйсээс хамааран ялгаатай тогтоох, элсүүлэхээс татгалзах, сургалтын ба бусад үйлчилгээ үзүүлэхийг хязгаарлах, татгалзах, эсхүл бусад арга, хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

13 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

13.1.Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгоход чиглэсэн арга хэмжээ авна.

13.2.Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зонхилон тохиолдож нас баралтын

үндсэн шалтгаан болж байгаа өвчлөлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгаж байна.

13.3.Хүсэзгүй жирэмслэлт, бэлгийн замын халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах эрхийг хүч хэрэглэх, тулган шаардах буюу аливаа арга, хэлбэрээр зөрчихийг хориглоно.

13.4.Эрэгтэй, эмэгтэй хүнийг нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн чиглэлийн бусад сургалт, сурталчилгаанд оролцох, үзлэг, шинжилгээнд хамрагдахад саад учруулахыг хориглоно.

13.5.Эрүүл мэндийн үйлчилгээнд эрэгтэй, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, үр хөндүүлэхийг ятгах, шаардах, дарамтлахыг хориглоно.

13.6.Орлого багатай, алслагдмал нутгийн хүн ам болон үндэстний цөөнхийн хүүхэд төрүүлэх, хүүхдээ асрах эрхийг хангах ба түүнд шаардлагатай туслалцаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авна.

14 дүгээр зүйл. Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа

14.1.Гэрлэгчид, төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүн ямар нэг байдлаар эхнэр, нөхөр, хамтын амьдралтай байгаа хүнээ мэргэжлээрээ ажиллах, бусад хэлбэрээр нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох эрхийг хязгаарлах, саад учруулахыг хориглоно.

14.2.Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэх, гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, гэрлэлтээ сайн дураараа цуцлуулах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн харилцаанд оролцох зэрэг хүний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно.

14.3.Эхнэр, нөхөр нь хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацаа зэргийг хамтран шийдвэрлэх, хүсэзгүй жирэмслэлтээс хамгаалах адил тэгш эрх, үүрэгтэй.

14.4.Эх, эцэг хүүхэддээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох үүрэгтэй.

14.5.Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хувь хөрөнгийг тогтооход оролцох, түүнийг захиран зарцуулах, орлого олох, гэр бүлийн бусад хэрэгцээг хангах үйл ажиллагаа явуулах гэр бүлийн гишүүний эрхийг хүйсийн шинжээр хязгаарлаж үл болно.

14.6.Эхнэр, нөхрийн гэрлэснээс хойш гэр ахуйн ажил ба өрхийн аж ахуй эрхэлсэн, хүүхэд, ахмад настныг асарсан зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээх болон өрхийн эдийн засагт оруулсан хувь хэмээн тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

15 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи Улсын Их Хурлын бүрэн эрх

15.1.Улсын Их Хурал жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.төрийн бодлого, хууль тогтоомжийг хүний эрхэд суурилсан жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байхаар тодорхойлох;

15.1.2.энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон жендэрийн эрх тэгш байдлын зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

15.1.3.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эмэгтэй, эрэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон төрийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүнгийн хэрэгжилтийг хангахуйц хөрөнгө батлах;

15.1.4.дараахь тайлан, илтгэлийг 2 жил тутам хэлэлцэж, дүгнэлт гаргах:

15.1.4.а.жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаархи Засгийн газрын тайлан;

15.1.4.б.жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаархи Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл;

15.1.4.в.төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаархи Төрийн албаны зөвлөлийн тайлан;

15.1.4.г.Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын ээлжит тайлан.

15.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

16 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи Засгийн газрын бүрэн эрх

16.1.Засгийн газар жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дараахь

бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөр, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, эдгээрийн хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн эх үүсвэрийг батлуулах;

16.1.2.хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэх, түүний дүнг хэрэглэгч болон олон нийтэд хүргэх нөхцөлийг хангах;

16.1.3.жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд хүний ба санхүүгийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

16.1.4.жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх гэгээрэл, сурталчилгааны ажлыг хүн амын дунд зохион байгуулах, хүнийг ялгаварлан гадуурхахад чиглэсэн мэдээлэл, ухуулга, сурталчилгаанаас олон нийтийг хамгаалах арга хэмжээ авах;

16.1.5.төрийн байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах зорилгод нийцүүлэн төрийн албаны стандарт батлан хэрэгжүүлэх;

16.1.6.жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх хэмжээний хүрээнд заавар, журам, зөвлөмж батлан гаргах;

16.1.7.жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үр дүнгийн талаар Улсын Их Хуралд тайлагнах.

16.2.Засгийн газар өрхийн аж ахуйн ба гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг үндэсний тооцооны өргөтгөсөн системд тусгах бодлого, арга зүйг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг хүлээнэ.

17 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрх

17.1.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал хамаарна.

17.2.Монгол Улсын Ерөнхий сайд Жендэрийн үндэсний хороог тэргүүлж, түүний үйл ажиллагааг удирдлагаар хангана.

18 дугаар зүйл. Жендэрийн үндэсний хорооны чиг үүрэг

18.1.Жендэрийн үндэсний хороо нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага мөн.

Жендэрийн үндэсний хороо ажлын албатай байна.

18.2.Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална.

18.3.Жендэрийн үндэсний хороо жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.3.1.жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

18.3.2.жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

18.3.3.жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;

18.3.4.жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхийг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

18.3.5.энэ хуулийн 15.1.4.а-д заасан тайланг бэлтгэх ажлыг зохион байгуулах;

18.3.6.энэ хуулийн 15.1.4.в, 15.1.4.г-д заасан тайлангийн төсөлтэй танилцах, санал өгөх;

18.3.7.энэ хуулийн 18.3.15-д заасан тайлангийн төслийг хэлэлцэх, санал өгөх;

18.3.8.жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн сүлжээ байгуулах, жендэрийн мэдээллийг хэрэглэгчид хүргэх ажлыг зохион байгуулах;

18.3.9.жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалахад олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангах;

18.3.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх;

18.3.11.жендэрийн салбар хороо, зөвлөлийн тайлан, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

18.3.12.жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлаар үр дүнд хүрсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг шагнал, урамшилд тодорхойлох;

18.3.13.Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын албаны бүтэц, зохион

байгуулалт, дүрмийг хэлэлцэж, батлуулах;

18.3.14.жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах;

18.3.15.жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын талаархи тайланг бэлтгэж Засгийн газарт оруулах;

18.3.16.жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх.

18.4.Жендэрийн үндэсний хороо нь орон нутагт салбар хороо, төрийн захиргааны төв байгууллагад салбар зөвлөлтэй байна.

18.5.Жендэрийн үндэсний хороо ажлаа Засгийн газарт тайлагнана.

19 дүгээр зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг

19.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1.тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

19.1.2.тухайн салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх;

19.1.3.салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгийн төслийг жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийсэн үнэлгээний тайлан, зөвлөмжийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлэх;

19.1.4.зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн салбар зөвлөл, хороо байгуулж, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

19.1.5.төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах;

19.1.6.тухайн салбар, орон нутгийн хэмжээнд жендэрийн сургалт, гэгээрлийн ажил явуулах;

19.1.7.энэ хуулийн 11.4-т заасан арга хэмжээг тухайн салбар, орон нутгийн онцлог, шаардлагад нийцүүлэн зохион байгуулах;

19.1.8.төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх;

19.1.9.төрийн захиргааны төв байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендэрийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх.

19.2.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хууль тогтоомж, бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, жендэрийн тэгш байдлын судалгаа, дүн шинжилгээний ажлыг жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

20 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

20.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар нутгийн өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, төрийн бодлогыг тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод тусгах, хэрэгжилтэд хяналт тавих;

20.1.2.харъяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх;

20.1.3.жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг дэмжиж, тэдгээртэй хамтран ажиллах;

20.1.4.жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараа оны 02 дугаар сарын 20-ны дотор Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх.

20.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тухайн шатны Засаг даргын тайланг хуралдаанаараа хэлэлцэж, дүнг нийтэд мэдээлнэ.

21 дүгээр зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг

21.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар Төрийн албаны зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.1.1.төрийн албаны хүйсээр ангилсан статистик мэдээ, мэдээллийн

тогтолцоог бүрдүүлэх, уг мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар бусад сонирхогч этгээдийг хангах;

21.1.2.төрийн албыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгахад чиглэсэн хэм хэмжээ, стандарт нэвтрүүлэх, тухайн асуудлаар энэ хуулийн 18.4-т заасан салбар, зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

21.1.3.төрийн албан дахь жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаархи гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавих;

21.1.4.энэ хуулийн 10.1, 10.3, 10.4, 11.3.2 дахь заалтын биелэлтэд хяналт тавих.

21.2.Энэ хуулийн 15.1.4.в-д заасан тайланг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

22 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон нийтийн байгууллагын оролцоо

22.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон нийтийн байгууллага дараахь оролцоотой байна:

22.1.1.жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, бусад шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавихад оролцох, иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах;

22.1.2.төрийн байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой мэдээлэл, санхүү, арга зүйн болон бусад дэмжлэг авах;

22.1.3.жендэрийн эрх тэгш байдлын талаар саналаа илэрхийлэх.

22.2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гэрээгээр хариуцан гүйцэтгэж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧСӨН ТАЛААРХИ ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

23 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдол гаргах

23.1.Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад зүйл, заалтыг зөрчсөн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах үндэслэл болно.

23.2.Энэ хуулиар баталгаажуулсан жендэрийн эрх тэгш байдлыг хангах, мөн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагыг аж

ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан зөрчсөн гэж үзвэл үйлдвэрчний эвлэлийн болон бусад олон нийтийн байгууллага гомдол гаргах эрхтэй.

23.3.Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан ажлын байрандаа жендэрийн ялгаварлан гадуурхалт гаргасан бол ажил олгогчийг нэгэн адил энэ хуулийг зөрчсөнд тооцно.

24 дүгээр зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн талаархи гомдлыг хянан шийдвэрлэх

24.1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ.

24.2.Жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн талаархи гомдлын үндэслэл хөдөлмөрийн гэрээ буюу хамтын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэх боломжтой нь тогтоогдвол гэрээний талууд гомдлыг хөдөлмөрийн ганцаарчилсан буюу хамтын маргааныг зохицуулах журмаар шийдвэрлэнэ.

24.3.Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гарсан маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.

24.4.Бэлгийн дарамтын талаархи гомдлыг хянан шийдвэрлэх явцад илэрсэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг хувийн нууц гэж үзэж, Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаална.

ТАВДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

25 дугаар зүйл. Гэм хор учирснаас үүсэх хариуцлага

25.1.Ажилтан хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад энэ хуулийг зөрчиж бусдад гэм хор учруулсан бол Иргэний хуулийн 498.1, 498.2-т заасны дагуу түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хариуцан арилгана.

25.2.Ажил олгогч энэ хуулийн 11.4-т заасан арга хэмжээ авсан болохоо нотолбол энэ хуулийн 25.1 дэх хэсэг хамаарахгүй.

26 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох

бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

26.2.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гаргаж өгөөгүй зэргээр Комиссын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

26.3.Гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

27.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тус тусын эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина.

27.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааны хэрэгжилтэд үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллага, иргэд олон нийтийн хяналт тавина.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-10.1.4 дэх заалт, 10.3 дахь хэсгийн заалтыг тодорхой үе шаттай хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар баталж, 2016 он хүртэл хугацаанд багтаан хэрэгжүүлнэ.

3 дугаар зүйл.

Энэ хуулийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хамгаалах” гэсний дараа “жендэрийн эрх тэгш байдлыг хангах“ гэж, 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “-жендэрийн хөгжлийн асуудал.” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “эрх чөлөөг” гэснийг “эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

---

14 дүгээр зүйл. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх

1.Хүний эрх, ***эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах*** эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.
/Энэ хэсэгт 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3.Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, ***жендэрийн эрх тэгш байдлыг хангах*** асуудлаар Засгийн газрын бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.
/Энэ хэсэгт 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг:

“5.3.Ажил олгогч нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

2/6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:

“6.3.Ажилтан нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “арьсны өнгө,” гэсний дараа “нас,” гэж, “хөрөнгө чинээ,” гэсний дараа “эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

---

5 дугаар зүйл. Ажил олгогчийн эрх, үүрэг
5.3.Ажил олгогч нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
/Энэ хэсгийг 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/
6 дугаар зүйл. Ажилтны эрх, үүрэг
6.3.Ажилтан нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
/Энэ хэсгийг 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/
7 дугаар зүйл. Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох
7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, **нас**, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, **эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол** шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.
/Энэ хэсэгт 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт:

“15.1.15.иргэнийг Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 4.1.5, 4.1.6, 6.4-т заасан жендэрийн шууд ба шууд бус хэлбэрээр ялгаварлан гадуурхах.”

2/17 дугаар зүйлийн 17.16 дахь хэсэг:

“17.16.Энэ хуулийн 17.4-т заасан сонгон шалгаруулалт болон 17.3-т заасан мэргэшлийн шалгалтад орж адил оноо авсан боловч хүйсийн шинжээр тэнцээгүй иргэн төрийн албаны төв байгууллагад гомдлоо гаргаж болно.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хүйс” гэсний өмнө “нас,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

---

15 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл
15.1.15.иргэнийг Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 4.1.5, 4.1.6, 6.4-т заасан жендэрийн шууд ба шууд бус хэлбэрээр ялгаварлан гадуурхах;
/Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/
16 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол
16.1.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно.
/Энэ хэсэгт 2011 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
17 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах
17.16.Энэ хуулийн 17.4-т заасан сонгон шалгаруулалт болон 17.3-т заасан мэргэшлийн шалгалтад орж адил оноо авсан боловч хүйсийн шинжээр тэнцээгүй иргэн төрийн албаны төв байгууллагад гомдлоо гаргаж болно. */Энэ хэсгийг 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/*

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 18.6 дахь хэсэг нэмсүгэй:

18.6.Энэ хуулийн 3.2-т заасан гишүүдээс нэг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

---

18 дугаар зүйл. Комиссын гишүүний хүний эрх , эрх чөлөөг хангах талаархи бусад бүрэн эрх

18.6.Энэ хуулийн 3.2-т заасан гишүүдээс нэг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцна.

/Энэ хэсгийг 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 129 | Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.7 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд Н.Номтойбаярт даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд Н.Номтойбаяр, Сангийн сайд Б.Чойжилсүрэн болон Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 274 дүгээр тогтоол, "Стратеги, төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.ЭРДЭНЭБАТ

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайд Н.НОМТОЙБАЯР

Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолын хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий мэдээлэл

Улсын Их Хурлаас 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаар үндэсний болон орон нутгийн түвшинд жендэрийн тэгш байдлын асуудлаар байгуулагдсан хороо, зөвлөлийн тоо 2 дахин нэмэгдэж, 13 төрийн захиргааны төв байгууллагад Жендэрийн үндэсний хорооны салбар зөвлөл, нийслэл, 21 аймаг, 9 дүүрэгт салбар хороо тус тус ажиллаж байна. Мөн үндэсний хэмжээнд анх удаа жендэрийн сургагч багш нарыг бэлтгэж, Жендэрийн үндэсний хорооны дэргэд жендэрийн асуудлаар мэргэшсэн Жендэрийн шинжээчдийн бүлэг, хэвлэл мэдээллийн зөвлөл, Жендэр консорциум ажиллаж байна.

Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан 2013-2016 онд хэрэгжүүлсэн бөгөөд “Хөгжлийн замнал” төрийн бус байгууллагаас хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр энэхүү стратеги, төлөвлөгөөний хэрэгжилт 60.1 хувьтай байсан байна.

Манай улсын хувьд 2002 онд эмэгтэй хүний дундаж наслалт 66.47, эрэгтэй хүнийх 60.75 байсан нь 2015 онд эмэгтэй хүнийх 75.84, эрэгтэй хүнийх 66.02 болж монгол хүний дундаж наслалт 6.28 насаар уртасчээ. Эрүүл мэндийн боловсрол олгох эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн нь жендэрийн хөгжлийн индексийг тодорхойлоход эерэгээр нөлөөлж, 2002 онд 0.667 байсан нь 2015 онд 1,045 болжээ.

Сүүлийн жилүүдэд хөвгүүдийн сургууль завсардалт буурч, их, дээд сургуульд суралцагчдын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэнээр жендэрийн зөрүүтэй байдал буурч байна. Мөн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах асуудалд хандах олон нийтийн хандлага сайжирч байна. Улсын хэмжээнд жилд дунджаар 17 000 хүн нас барж байгаагийн 62 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн нас баралтын 33 хувийг зүрх судасны өвчлөл, гадны нөлөөллөөс болсон осол гэмтэл 24.9 хувийг, хавдар 19.4 хувийг эзэлж байна. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад (10 000 хүн тутамд) эрэгтэйчүүдийн амиа хорлох үзэгдэл 5.5 дахин, хүчирхийлэл үйлдэх хандлага 3.6 дахин, зам тээврийн осолд өртөх тохиолдол 3.4 дахин өндөр байна.

Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээллээр 2017 оны эхний 3 сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас 340 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл авч 3 хүн нас барсан байна. Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах "Нэг цэгийн үйлчилгээний төв"-өөр нийт 79 иргэн үйлчлүүлсний 40 нь эмэгтэй, 2 нь эрэгтэй, 37 нь хүүхэд, "Түр хамгаалах байр"-нд нийт 72 иргэн үйлчлүүлсний 23 нь эмэгтэй, 4 нь эрэгтэй, 45 нь хүүхэд байна.

Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, түүний дотор нөхөн үржихүйн насны болон бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхолгүй байх, эмэгтэйчүүдийг эрт тэтгэвэрт гаргах үзэгдэл түгээмэл байна. 2015 оны байдлаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин эмэгтэй хүнийх 760.7 мянган төгрөг, эрэгтэй хүнийх 856.0 мянган төгрөг, цалингийн зөрүү нь 95.3 мянган төгрөг байна. Монгол Улсын хэмжээнд 2016 оны байдлаар өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээ эрэгтэй хүнийх 367.9 мянган төгрөг, эмэгтэй хүнийх 299.5 мянган төгрөг байгаа бөгөөд эмэгтэй тэтгэвэр авагч нь эрэгтэйгээс 68.4 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар бага хэмжээний тэтгэвэр авч байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны идэвх сайжирсан бөгөөд Улсын Их Хурал, орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшиж байгаа эмэгтэйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа хэдий ч аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 15.8 хувь нь, Улсын Их Хурлын гишүүдийн 17.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ахиц, дэвшил гарч байгаа боловч хууль хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийг хүрэлцээтэй хуваарилах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал байсаар байна.

Иймд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны Эх дэлхийгээ шинэчилье, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн 5 дугаар зорилт, "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх зорилт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-ийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг хангах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлнэ:

2.2.1. нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх;

2.2.2. жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх;

2.2.3. эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх;

2.2.4. жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх;

2.2.5. хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.2.6. улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

2.3. Хөтөлбөрийн хугацаа

Хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтийг үнэлэх

үзүүлэлтийг тодорхойлж нэвтрүүлэх;

3.1.2. иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульд тусгах;

3.1.3. ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах;

3.1.4. адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох үнэлгээний аргачлал боловсруулах;

3.1.5. малчин, тариаланч өрхийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.6. эмэгтэй, эрэгтэй хүн болон нийгмийн бүлгийн хэрэгцээнд нийцсэн, тэгш хүртээмжтэй ногоон ажлын байр бий болгох, үндэсний болон бусад улсын сайн туршлагыг судлах;

3.1.7. “Ядуурлын эсрэг, тэгш оролцоот, хүртээмжит ногоон хөгжлийн хандлага”-ыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулан түгээх;

3.1.8. олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих;

3.1.9. гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн эмч, мэргэжилтний ур чадварыг сайжруулах, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх;

3.1.10. эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийг бүх аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллуулж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах;

3.1.11. улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх;

3.1.12. эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавх олгох цуврал сургалт зохион байгуулах;

3.1.13. эрүүл мэнд, нөхөн үржихүй, ялангуяа бэлгийн боловсрол олгох хичээлийн агуулгыг насны болон жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлгийн онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд

албан сургалтаар, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт оруулах.

3.2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1.жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах программ хангамжийг нэвтрүүлэх;

3.2.2. жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж хуулиар үүрэг хүлээгчдэд хүргүүлэх;

3.2.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгах арга хэмжээ авах;

3.2.4. нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа эмэгтэй, эрэгтэй тэтгэвэр авагчдын дунд судалгаа хийж, тэтгэврийн зөрүүтэй байдлыг арилгах талаар санал боловсруулах;

3.2.5. иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгах чиглэлээр ажиллах;

3.2.6. эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх болон оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийх;

3.2.7. залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах;

3.2.8. салбарын болон орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх;

3.2.9. орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, салбар хороодоос сум, баг, хороотой хамтран ажиллах удирдамж гаргах;

3.2.10. бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах;

3.2.11. салбарын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.2.12. төрийн байгууллагын төсөв боловсруулах үүрэгтэй ажилтныг жендэрийн мэдрэмжтэй төсөв хийх цахим сургалтад хамруулах;

3.2.13. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийж,

төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, үнэлэх аргачлал боловсруулах;

3.2.14. гадаад улсын болон олон улсын байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр манай улсад оруулсан хувь нэмэр, зарцуулсан санхүүжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн, зөвлөмж хүргүүлэх.

3.3. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. багш бэлтгэх сургууль болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн асуудлыг тусгах;

3.3.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш), эрүүл мэнд (эмч, сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэх;

3.3.3. бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, сурах бичигт жендэрийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, хандлагыг төлөвшүүлэх асуудлыг тусгах;

3.3.4. бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндлэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах;

3.3.5. гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах;

3.3.6. гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх арга хэмжээг дэмжиж, аймаг, дүүргийн хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөө өгөх бүтэц, хүний нөөцийг бэлтгэх;

3.3.7. Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагатай хамтран боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах;

3.3.8. хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх;

3.3.9. сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах;

3.3.10. жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах;

3.3.11. соёл урлагийн салбарын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг арилгах жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх;

3.3.12. бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийг тогтмол гаргах;

3.3.13. эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насныханд зориулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.3.14. нийгэм дэх манлайлагч, олны танил эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх.

3.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. жендэрийн салбар зөвлөл болон хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварыг баталж мөрдүүлэх;

3.4.2. Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх жендэрийн шинжээчдийн бүлэг, Жендэр консорциум, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих;

3.4.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх;

3.4.4. төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үндэсний сургагч багш бэлтгэх;

3.4.5. сум, хорооны Засаг даргын Тамгын газрын залуучууд, гэр бүл, хүн амын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага боловсруулж, сургалтад хамруулах;

3.4.6. удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модуль боловсруулан нэвтрүүлэх;

3.4.7. Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах шалгуурт жендэрийн эрх тэгш байдлын үзүүлэлтийг тусгах;

3.4.8. ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих хөшүүргийг тодорхойлж сурталчлах;

3.4.9. жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах;

3.4.10. аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр орон нутаг дахь төрийн бус байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

3.5. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

3.5.1. хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах заавар боловсруулан Хүний эрхийн үндэсний комисс болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, холбогдох ажилтанд хүргүүлж, сургалтад хамруулах;

3.5.2. охид, эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх;

3.5.3. хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх;

3.5.4. аж ахуйн нэгж, байгууллагад хүчирхийлэл, түүний дотор ажлын байр дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.5.5. хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж (Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байр зэрэг)-ийг бүх аймагт ажиллуулж, үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх.

3.6. улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.6.1. улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх;

3.6.2. эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

3.6.3. нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх арга хэмжээ авах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. салбаруудын жендэрийн бодлого болон бүх аймаг, дүүргийн

жендэрийн дэд хөтөлбөр батлагдсан байна.

4.1.2. жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.

4.1.3. жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавх бэхэжсэн байна.

4.1.4. хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж бүх аймаг, дүүрэгт ажиллана.

4.1.5. шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэн байна.

4.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Суурь түвшин (2015 он)	Дунд хуга цаанд үнэлэх түвшин (2019 он)	Зорилтот түвшин (2021 он)	Мэдээл-лийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллагууд
1.	Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг дотоод журамдаа тусгасан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	хувь	-	20 хувь	35 хувь	ХНХЯ	ХНХЯ, (ЖҮХ), ХЗДХЯ, МҮХАҮТ, МАОЭНХ, МҮЭХ
2.	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет	тоо	11	20	30	ЭМЯ	ЭМЯ, СЯ, ЖҮХ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ
3.	Монгол Улсын жендэрийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээ	тоо	-	1	1	ХНХЯ	ХНХЯ, ЖҮХ, ТББ
4.	Яамд (салбар)-ын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн тоо	тоо	яам-3 аймаг-3	яам-7 аймаг, дүүрэг-20	бүх яам аймаг, дүүрэг- 30	ХНХЯ	ЖҮХ, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, сум, дүүргийн ЗДТГ
5.	оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийсэн яам (салбар), аймаг, дүүрэг	тоо	яам-3 аймаг, дүүрэг-	яам-7 аймаг, дүүрэг-20	бүх яам аймаг, дүүрэг-30	ХНХЯ	ЖҮХ, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, дүүргийн ЗДТГ

6.	Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эрэгтэйчүү-дийн эзлэх хувь	хувь	18 хувь	35 хувь	50 хувь	БСШУСЯ	БСШУСЯ, ЖҮХ
7.	Мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэй-чүүдийн эзлэх хувь	хувь	30 хувь	40 хувь	50 хувь	БСШУСЯ	БСШУСЯ, ЖҮХ
8.	Жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ хийгдсэн хэвлэл мэдээллийн байгууллага	тоо	2	10	20	Сэтгүүлч-дийн нэгдсэн эвлэл	ЖҮХ, СНЭ, Глоб интернэйшнл, Хэвлэлийн хүрээлэн, ХМБ
9.	Жендэрийн үндэсний сургагч багшийн тоо	тоо	90	135	180	ХНХЯ, ЖҮХ	БСШУСЯ, төрийн захиргааны төв байгууллага
10.	Жендэрийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан (УА), төрийн албан хаагч (ТАХ)	хувь	УА-15 хувь ТАХ-25 хувь	УА-35 хувь ТАХ-45 хувь	УА-65 хувь ТАХ-75 хувь	ТАЗ	ЖҮХ, Удирдлагын академи, ТББ
11.	Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутаг дахь төрийн бус байгууллагаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо	тоо	-	15	30	Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, жендэр-ийн салбар хороо	ЖҮХ, ТББ
12.	Аймаг, нийслэл, дүүрэгт ажиллаж байгаа хохирогчийг хамгаалах нэгжийн тоо	тоо	10	20	30	ХЗДХЯ (ГХУСАЗЗ)	СЯ, ЖҮХ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ИТХ, ТББ

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.4. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих, үр дүнд үнэлгээ хийх чиг үүргийг жендэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллах, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр гаргах, олон нийтэд мэдээлэх үүргийг Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба хариуцна.

6.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.3.1. төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь салбарын, нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр хувийн хэвшлээс санхүүгийн дэмжлэг авах ажлыг зохион байгуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ;

6.3.2. нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх жендэрийн дэд хөтөлбөрийг баталж, үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлан төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн

идэвх санаачилгыг дэмжин хамтран ажиллана;

6.3.3. төрийн бус байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр иргэдийн санал, санаачилгыг идэвхжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийнэ;

6.3.4. аж ахуйн нэгж, байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож санхүүгийн дэмжлэг үзүүлнэ;

6.3.5. хэвлэл мэдээллийн байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчих, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна;

6.3.6. төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа жилийн 2 дугаар сарын 20-нд багтаан жендэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.4. Жендэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах хэлбэрээр зохион байгуулна:

6.4.1. хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хөндлөнгийн үнэлгээний зардлыг жил бүр төсөвт тусган батлуулах;

6.4.2. 2019 онд хөтөлбөрийн дунд хугацааны зорилтот түвшин болон 2022 онд хөтөлбөрийн зорилтот түвшинд хүрсэн байдалд жендэрийн асуудлаар мэргэшсэн судалгааны байгууллага, багаар хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлгэх.

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2021)

**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ**

2017 оны 08 сарын 07 өдөр Дугаар А/152 Улаанбаатар хот

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батлагдсугай.

2. Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолын 6.3.6-д заасан болон арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд Жендэрийн үндэсний хорооны ажлын албанд ирүүлсүгэй.

3. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний салбар дундын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир)-т үүрэг болгосугай.

4. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох журмын дагуу Засгийн газарт танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Менхзул)-т үүрэг болгосугай.

САЙД Н.НОМТОЙБАЯР



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 08 дугаар сарын 03-ний өдрийн
А/163 тушаалын хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2021)

Зорилго	Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг дэмжих, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах
Үр дүн	1. Салбаруудын жендэрийн бодлого болон бүх аймаг, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөр батлагдсан байна. 2. Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна. 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавх бэхэжсэн байна. 4. Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж бүх аймаг, дүүрэгт ажиллана. 5. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэн байна.

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх						
1.1	Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлж нэвтрүүлэх	байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хэмжих үзүүлэлт бүхий удирдамж	хөдөлмөрийн дотоод журамдаа удирдамжийг ашигласан байгууллагын тоо, хувь	ХНХЯ[1]	ХЭҮК[2], ХЗДХЯ[3], МҮХАҮТ[4], АОЭНХ[5], МҮЭХ[6], ОУБ[7]	2018-2021

[1] *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*
[2] *Хүний эрхийн үндэсний комисс*
[3] *Хууль зүй, дотоод хэргийн яам*
[4] *Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим*
[5] *Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо*
[6] *Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо*
[7] *Олон улсын байгууллага*

1.2	Иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульд тусгах	хууль тогтоомжийн төсөл	Хууль тогтоомжийн зохицуулалтын байдал, хувь	ХЗДХЯ	ХЭҮК, ХНХЯ, МҮЭХ, МҮХАҮТ, АОЭНХ	2018-2021
1.3	Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах	ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах	бодлогыг нэвтрүүлсэн байгууллагын тоо, хувь	ХНХЯ	МҮЭХ, ТББ[8], ОУБ	2018-2020
1.4	Адил хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэй, эрэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох үнэлгээний аргачлал боловсруулах	үнэлгээний аргачлал	үнэлгээний аргачлалын хэлэцүүлгийн тоо	ХНХЯ	МҮЭХ, МҮХАҮТ, АОЭНХ ОУБ	2018-2019
1.5	Малчин, тариаланч ерхийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавих	жендэрийн дүн шинжилгээний аргачлал, зөвлөмж	зөвлөмжийг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	ХХААХҮЯ[9]	ХНХЯ, ТББ, ОУБ	2018-2020
1.6	Эмэгтэй, эрэгтэй хүн болон нийгмийн бүлгийн хэрэгцээнд нийцсэн, тэгш хүртээмжтэй ногоон ажлын байр бий болгох үндэсний болон бусад улсын сайн туршлагыг судлах	судалгааны тайлан	сайн туршлагыг түгээсэн нөлөөллийн үйл ажиллагааны тоо	БОАЖЯ[10]	ХНХЯ, ТББ, ОУБ	2018-2019

[8] Төрийн бус байгууллага
[9] Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
[10] Байгаль орчин, аялал жуулчлалын яам

1.7	Ядуурлын эсрэг, тэгш оролцоот, хүртээмжит ногоон хөгжлийн хандлагыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулан түгээх	гарын авлага	гарын авлага түгээсэн байгууллагын тоо	БОАЖЯ	ХНХЯ, ТББ, ОУБ	2018-2019
1.8	Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих	үйл ажиллагааны төлөвлөгөө	үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	ХНХЯ	ХХҮЕГ[11], ТББ, ОУБ	2018-2021
1.9	Гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх эмч, мэргэжилтний ур чадварыг сайжруулах, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх	эмч, мэргэжилтэнд зориулсан сургалт, мэдээлэл сурталчилгааны материал	сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо мэдээлэл, сурталчилгааны тоо	ЭМЯ[12]	ХНХЯ, ГБХЗХГ[13], ТББ, ОУБ	2018-2021
1.10	Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийг бүх аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллуулж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах	хүний нөөц, техник төхөөрөмж, тасаг, кабинет	эрэгтэйчүүдийн тасаг, кабинеттай аймаг, дүүргийн тоо, эмч нарын тоо	ЭМЯ	СЯ[14], аймаг, дүүргийн ЗДТГ[15], Нэгдсэн эмнэлэг, НӨУБ[16]	2018-2021

[11] Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
[12] Эрүүл мэндийн яам
[13] Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
[14] Сангийн яам
[15] Засаг даргын тамгын газар
[16] Нутгийн өөрөө удирдах байгууллага

1.11	Улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх	жендэрийн дүн шинжилгээний тайлан	дүн шинжилгээний зөвлөмжийг танилцуулж, сурталчилсан арга хэмжээний тоо	ЭМЯ	УУХҮЯ[17], ХНХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, НӨУБ, ТББ, ОУБ	2019-2020
1.12	Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавх олгох цуврал сургалт зохион байгуулах	цуврал сургалтын хөтөлбөр	цуврал сургалтанд хамрагдагчийн тоо, хувь	ЭМЯ	ТББ, ОУБ	2017-2018
1.13	Эрүүл мэнд, нөхөн үржихүй, бэлгийн боловсрол олгох хичээлийн агуулгыг насны болон жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлгийн онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд албан сургалтаар, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт оруулах	хичээлийн хөтөлбөр	ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусгасан хувь	ЭМЯ	БСШУСЯ[18]	2018-2020
Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх						
2.1	Жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах программ хангамжийг нэвтрүүлэх	программ хангамж	программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байгууллагын тоо	ҮСХ[19]	ХНХЯ, ОУБ	2017-2018
2.2	Жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж хуулиар үүрэг хүлээгчдэд хүргүүлэх	аргачлал	аргачлалыг ашигласан байгууллагын хувь	ХНХЯ/ЖҮХ[20]	холбогдох төрийн байгуул-лагууд, ТББ	2018

[17] *Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам*
[18] *Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам*
[19] *Үндэсний статистикийн хороо*
[20] *Жендэрийн үндэсний хороо*

2.3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгах арга хэмжээ авах	хяналт шинжилгээ үнэлгээний тайлан	хэлэлцүүлгийн тоо	ХНХЯ/ЖҮХ	ТББ, ОУБ	2018
2.4	Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа эмэгтэй, эрэгтэй тэтгэвэр авагчдын дунд судалгаа хийж, тэтгэврийн зөрүүтэй байдлыг арилгах талаар санал боловсруулах	судалгааны тайлан	саналын хэлэлцүүлгийн тоо	ХНХЯ	ЭМНДЕГ[21], ТББ, ОУБ	2018-2019
2.5	Иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгах чиглэлээр ажиллах	дүн шинжилгээний тайлан	үр дүнг тусгасан бодлого, үйл ажиллагааны тоо	ХНХЯ/ЖҮХ	ХЗДХЯ, ОӨУБЕГ[22], ТББ, ОУБ	2018-2020
2.6	Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх болон оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийх	судалгааны тайлан	судалгааны хэлэлцүүлгийн тоо	ХНХЯ/ЖҮХ	ЭМЯ, БСШУСЯ, ГБХЗХГ, ТББ, ОУБ	2018-2019
2.7	Залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах	судалгааны тайлан	авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	ХХААХҮЯ	ХНХЯ, ГБХЗХГ, аймаг, дүүргийн ЗДТГ, ТББ, ОУБ	2018-2019
2.8	Салбарын болон орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх	оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээг хэлэлцсэн тайлан	оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийсэн салбар, орон нутгийн тоо	ХНХЯ/ЖҮХ	Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ТББ, ОУБ	2017-2021

[21] *Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар*
[22] *Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар*

2.9	Орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хороодоос сум, баг, хороотой хамтран ажиллах удирдамж гаргах	удирдамж	удирдамжийг хэрэгжүүлсэн нэгжийн тоо	ХНХЯ/ЖҮХ	Аймаг, нийслэл, сум дүүрэг, баг, хорооны ЗДТГ, НӨУБ, ТББ, ОУБ	2018-2019
2.10	Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах	бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгох зохицуулалт	үр дүнгийн гэрээнд тусгасан тоо, хувь	ХНХЯ/ЖҮХ	Аймаг, нийслэл, сум дүүргийн, ЗДТГ, НӨУБ, ТББ	2018-2021
2.11	Салбарын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	үйл ажиллагааны төлөвлөгөө	батлагдсан салбарын жендэрийн бодлого, дэд хөтөлбөрийн тоо	ХНХЯ/ЖҮХ	ТББ, ОУБ	2017-2021
2.12	Төрийн байгууллагын төсөв боловсруулах үүрэгтэй ажилтныг жендэрийн мэдрэмжтэй төсөв хийх цахим сургалтад хамруулах	цахим сургалтын хөтөлбөр	сургалтанд хамрагдагчдын тоо	СЯ	Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, НӨУБ, ТББ	2018-2021
2.13	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийж, төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, үнэлэх аргачлал боловсруулах	гарын авлага, аргачлал	төсвийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх аргачлал, гарын авлага хэрэглэсэн байгууллагын тоо, хувь	СЯ	ТББ, ОУБ	2017-2018
2.14	Гадаад улсын болон олон улсын байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр манай улсад оруулсан хувь нэмэр, зарцуулсан санхүүжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн, зөвлөмж хүргүүлэх	зөвлөмж	зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо, хувь	ХНХЯ/ЖҮХ	СЯ, ТББ	2018-2021

Зорилт 3. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх						
3.1	Багш бэлтгэх сургууль болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн асуудлыг тусгах	жендэрийн үнэлгээний тайлан	жендэрийн асуудлыг тусгасан сургуулийн тоо	БСШУСЯ	ТББ, ОУБ	2017-2018
3.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш), эрүүл мэнд (эмч, сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэх	бодлогыг хэрэгжүүлэх шийдвэр	боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь Мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	БСШУСЯ	ТББ	2018-2020
3.3	Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, сурах бичигт жендэрийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, хандлагыг төлөвшүүлэх асуудлыг тусгах	сургалтын хөтөлбөр	сургалтын хөтөлбөрт тусгасан байдал, хувь	БСШУСЯ	ХЗДХЯ/ ГХУСАЗЗ[23], ХНХЯ, ТББ	2017-2018
3.4	Бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндлэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах	сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, хөтөлбөр	сургалтанд хамрагчдын тоо, сурталчилгааны тоо	ХНХЯ	ГБХЗХГ, ТББ, ОУБ	2017-2018

[23] *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл*

3.5	Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах	арга хэмжээний төлөвлөгөө	зохион байгуулсан арга хэмжээний тоо	ХНХЯ	ГБХЗХГ, ТББ, ОУБ	2017-2018
3.6	Гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх арга хэмжээг дэмжиж, хүний нөөцийг бэлтгэх;	эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөө өгөх бүтэц, хүний нөөц	эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөө өгөх бүтэцтэй аймаг, дүүргийн тоо	ХНХЯ	ГБХЗХГ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ТББ	2017-2021
3.7	Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагатай хамтран боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах;	шалгуур үзүүлэлт, баталсан бодлого, ёс зүйн код	шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн ахисан хувь	ХНХЯ/ЖҮХ	СНЭ[24], Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ[25], ОУБ	2018-2019
3.8	Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх	жендэрийн дүн шинжилгээний тайлан	дүн шинжилгээний зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо, хувь	ХНХЯ/ЖҮХ	СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ТББ, ОУБ	2018
3.9	Сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах	хөтөлбөрийн жендэрийн агуулга, сургалт	жендэрийн агуулга бүхий хөтөлбөртэй сургууль, сургалтад хамрагдагчийн тоо, хувь	ХНХЯ/ЖҮХ	БСШУСЯ, СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ТББ	2017-2021

[24] *Сэтгүүлчдийн нэгдсэн эвсэл*
[25] *Хэвлэл мэдээллийн байгууллага*

3.10	Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах	компанит ажлын хөтөлбөр, төлөвлөгөө	компанит ажилд оролцсон ХМХ, үйл ажиллагааны тоо	ХНХЯ/ЖҮХ	СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ОУБ	2018-2021
3.11	Соёл урлагийн салбарын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг арилгах жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх	бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө	үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	БСШУСЯ	ТББ, ОУБ	2018-2021
3.12	Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийг тогтмол гаргах	нийтлэлийн булан нэвтрүүлэг	нийтлэлийн булан, нэвтрүүлгийн цагтай хэвлэл мэдээллийн байгууллагын тоо	ХНХЯ/ЖҮХ	СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ОУБ	2018-2021
3.13	Эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насныханд зориулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	сургалт, төсөл хөтөлбөр	оролцогчдын хувь	ХНХЯ/ЖҮХ	ГБХЗХГ, ТББ, ОУБ	2017-2021
3.14	Нийгэм дэх манлайлагч, олны танил эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх	сурталчилгааны материал	сурталчилгаа хийсэн ХМХ-ийн тоо, хувь	ХНХЯ/ЖҮХ	СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ТББ, ОУБ	2018-2021
Зорилт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх						
4.1	Жендэрийн салбар зөвлөл болон хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварыг баталж мөрдүүлэх	журам	журмыг мөрдсөн салбар зөвлөл, хорооны тоо	ХНХЯ/ЖҮХ		2017-2021
4.2	Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Жендэрийн шинжээчдийн бүлэг, Жендэр консорциум, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	төлөвлөгөө	төлөвлөгөөний биелэлтийн хувь	ХНХЯ/ЖҮХ	ТББ, ОУБ	2017-2021

4.3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх	үнэлгээний тайлан	тайлангийн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо	ХНХЯ/ЖҮХ	ТББ, ОУБ	2017-2021
4.4	Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үндэсний сургагч багш бэлтгэх	сургалтын төлөвлөгөө	бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	ХНХЯ/ЖҮХ	ТАЗ[26], ТББ, ОУБ	2017-2021
4.5	Сум, хорооны Засаг даргын Тамгын газрын залуучууд, гэр бүл, хүн амын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага боловсруулж, сургалтад хамруулах	гарын авлага	сургалтанд оролцогчдын тоо	ХНХЯ	ГБЗХГ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ТББ, ОУБ	2018-2021
4.6	Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модуль боловсруулан нэвтрүүлэх	цахим сургалтын модуль	сургалтанд оролцогчдын тоо	ХНХЯ/ЖҮХ	ТАЗ, ЗГХЭГ[27], СЯ, УА[28], ТББ, ОУБ	2017-2021
4.7	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах шалгуурт жендэрийн эрх тэгш байдлын үзүүлэлтийг тусгах	аж ахуйн нэгж шалгаруулах шалгуур дахь жендэрийн үзүүлэлт	жендэрийн үзүүлэлтийн тоо	ХНХЯ	МҮХАҮТ, ТББ, ОУБ	2018-2019
4.8	Ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих хөшүүргийг тодорхойлж сурталчлах	жендэрийн тэгш байдлыг дэмжих санхүү эдийн засаг, бизнес, техник технологийн хөшүүргүүдийг тодорхойлсон зөвлөмж	зөвлөмжийг сурталчилсан арга хэмжээний тоо	ХНХЯ	МҮХАҮТ, МҮЭХ, АОЭНХ, ТББ, ОУБ	2018-2020

[26] *Төрийн албаны зөвлөл*
[27] *Засгийн газрын хэрэг эрхлэх газар*
[28] *Удирдлагын академи*

4.9	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах	сайн туршлага бүхий сурталчилгааны материал	сурталчилгааны тоо	ХНХЯ/ЖҮХ	МҮХАҮТ, МҮЭХ, АОЭНХ, ТББ, ОУБ	2018-2020
4.10	Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр орон нутаг дахь төрийн бус байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	ТББ-уудын хийсэн үнэлгээний тайлан	үнэлгээ хийлгэсэн аймаг, нийслэл, дүүргийн тоо	ХНХЯ/ЖҮХ	ТББ, ОУБ	2017-2021
Зорилт 5. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх						
5.1	Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах заавар боловсруулан Хүний эрхийн үндэсний комисс болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, холбогдох ажилтанд хүргүүлж, сургалтад хамруулах	сургалтын хөтөлбөр	оролцогчдын тоо, хувь	ХЭҮК	ХНХЯ, ГБХЗХГ, ГХУСАЗЗ, ТББ, ОУБ	2017-2019
5.2	Охид, эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх	үйл ажиллагааны төлөвлөгөө	төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ХЗДХЯ	ХНХЯ, ЦЕГ[29], ГХУСАЗЗ, ТББ, ОУБ	2017-2021
5.3	Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх	мэдээлэл сурталчилгаа	мэдээлэл түгээсэн байдал, хувь	ХЗДХЯ/ ГХУСАЗЗ	ХНХЯ, СНЭ, Хэвлэлийн хүрээлэн, бусад ХМБ, ТББ, ОУБ	2017-2021

[29] *Цагдаагийн ерөнхий газар*

5.4	Аж ахуйн нэгж, байгууллагад хүчирхийлэл, түүний дотор ажлын байр дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	хууль тогтоомжийн төсөл	хууль тогтоомжийн зохицуулалтын байдал, хувь	ХНХЯ	МҮЭХ, МҮХАТ, АОЭНХ, ТББ, ОУБ	2017-2018
5.5	Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж (Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байр зэрэг)-ийг бүх аймагт ажиллуулж, үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх	хохирогчийг хамгаалах нэгж	төсөвт үйл ажиллагааны зардал нь тусгагдсан хохирогчийг хамгаалах нэгжийн тоо	ХЗДХЯ/ ГХУСАЗЗ	ХНХЯ, СЯ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, НӨУБ, ТББ, ОУБ	2017-2021
	Зорилт 6. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх					
6.1	Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх	квотын хэрэгжилт	квотыг хэрэгжүүлсэн улс төрийн болон төрийн захиргааны байгууллагын тоо	ТАЗ	Төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага, улс төрийн нам	2017-2021
6.2	Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	хамтын ажиллагааны хөтөлбөр	хөтөлбөрт хамтрагдсан ТББ-ын тоо	ХНХЯ/ЖҮХ	ТББ, ОУБ	2017-2021
6.3	Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх арга хэмжээ авах	арга хэмжээний төлөвлөгөө	жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлсэн байгууллагын тоо	ХНХЯ/ЖҮХ	НӨУБ, ТББ, ОУБ	2018-2021

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны
27 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд

Орлогч дарга - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

Гишүүд: - Сонгуулийн ерөнхий хорооны дарга (зөвшилцсөнөөр);

- Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр);
- Хүний эрхийн үндэсний комиссын орон тооны гишүүн (зөвшилцсөнөөр);
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч;
- Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын эрэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

- Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны Хөгжлийн бодлогын газрын дарга (тохиролцсоноор);

- “Гал голомт” үндэсний хөдөлгөөний тэргүүн (тохиролцсоноор);

- Нийгмийн ардчилал-Монголын эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

- Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

- “Иргэний зориг” эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

- Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);

- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн сүлжээний зохицуулагч (тохиролцсоноор);

- Хэвлэлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал;

- Хараат бус судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал;

- “МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээний зохицуулагч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга - Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны дарга.

Жендэрийн үндэсний хорооны салбар зөвлөл

- Монгол Улсын 13 яаманд салбар зөвлөл, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй.

Жендэрийн үндэсний хорооны салбар хороо

- Монгол Улсын 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт салбар хороотой, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

КОНВЕНЦИЙН АГУУЛГА

УДИРТГАЛ

I ХЭСЭГ

- Ялгаварлан гадуурхалт (1-р зүйл)
- Бодлогын арга хэмжээ (2-р зүйл)
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөны баталгаа (3-р зүйл)
- Тусгай арга хэмжээ (4-р зүйл)
- Эрэгтэй, эмэгтэй хүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, хэвшмэл ойлголт (5-р зүйл)
- Биеэ үнэлэх (6-р зүйл)

II ХЭСЭГ

- Улс төр, олон нийтийн амьдрал (7-р зүйл)
- Төлөөлөл (8-р зүйл)
- Иргэншил (9-р зүйл)

III ХЭСЭГ

- Боловсрол (10-р зүйл)
- Ажил эрхлэлт (11-р зүйл)
- Эрүүл мэнд (12-р зүйл)
- Эдийн засаг, нийгмийн үр ашиг (13-р зүйл)
- Хөдөөгийн эмэгтэйчүүд (14-р зүйл)

IV ХЭСЭГ

- Хууль эрх зүй (15-р зүйл)
- Гэрлэлт ба гэр бүлийн амьдрал (16-р зүйл)

V ХЭСЭГ

- Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах Конвенцийн хороо
- (17-р зүйл)
- Үндэсний тайлан (18-р зүйл)
- Журам дүрэм (19-р зүйл)
- Хорооны хурал (20-р зүйл)
- Хорооны тайлан (21-р зүйл)
- Мэргэжлийн байгууллагуудын үүрэг (22-р зүйл)

VI ХЭСЭГ

- Бусад гэрээ, нөлөө (23-р зүйл)
- Оролцогч улсуудын амлалт (24-р зүйл)
- Конвенцийн удирдлага (зүйл 25-30)

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж,1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү Конвенцид оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм нь хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнэ болон эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхэд итгэдгээ дахин бататгасныг тэмдэглэж;

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь алагчилах үзлийг зөвшөөрөхгүй байх зарчмыг бататган, хүн бүр эрх чөлөөтэй, нэр төр, эрхийн хувьд тэгш төрдөг бөгөөд тус тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг аливаа ялгаварлалгүйгээр, тухайлбал, хүйсээр ялгаварлалгүйгээр эдлэх ёстой хэмээн зарлан тунхагласныг тэмдэглэж;

эрэгтэй, эмэгтэйчүүдийг эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон улс төрийн бүх эрхийг тэгш эдлэх эрхээр хангах үүргийг хүний эрхийн тухай олон улсын гэрээнүүдэд оролцогч улсууд хүлээснийг тэмдэглэж;

эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагуудын ивээл дор байгуулсан олон улсын конвенцийг анхааралдаа авч;

түүнчлэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагуудаас батласан тогтоол, тунхаглал, зөвлөмжийг тэмдэглэж;

эдгээр олон төрлийн баримт бичиг байгаа хэдий ч эмэгтэйчүүдийг алагчилах үзэл оршсоор байгаад сэтгэл түгшиж;

эмэгтэйчүүдийг алагчилах үзэл тэгш эрх, хүний нэр төрийг хүндэтгэх зарчмыг зөрчиж, эмэгтэйчүүд улсынхаа улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд эрэгтэйчүүдийн нэгэн адил оролцоход нь саад учруулж, нийгэм болон гэр бүлийн хөгжил цэцэглэлтийг саатуулж, эмэгтэйчүүдээс улсынхаа болон хүн төрөлхтний үйлсэд хувь нэмэр оруулах бололцоогоо бүрэн хөгжүүлэхэд нь илүү бэрхшээл учруулж байгааг ухамсарлаж;

ядуурлын нөхцөлд хоол хүнс хүртэх, эрүүл мэндээ хамгаалах, боловсрол олох, мэргэжил эзэмших, хөдөлмөр эрхлэх болон бусад хэрэгцээгээ хангах

боломжоор эмэгтэйчүүд хамгийн хомс байгаад сэтгэл түгшиж;

тэгш эрх, шударга ёсонд үндэслэсэн олон улсын эдийн засгийн шинэ журам тогтоох нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хөхиүлэн дэмжихэд мэдэгдэхүйц дөхөм үзүүлнэ хэмээн итгэж;

апартеид, арьс үндэсний үзэл, арьс үндсээр алагчилах, колоничлол, шинэ колоничлол, түрэмгийлэл, гадаадын булаан эзлэлт, ноёрхол болон улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох бүхий л хэлбэрийг устгах нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрхийг бүрэн эдлүүлэхэд чухал болохыг онцлон тэмдэглэж;

олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, олон улсын хурцадмал байдлыг намжаах, бүх улс нийгэм, эдийн засгийн тогтолцооноосоо үл хамааран хамтран ажиллаж, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, ялангуяа олон улсын хатуу, үр нөлөөтэй хяналтын дор цөмийн зэвсгийг хураах, улс хоорондын харилцаанд шударга ёс, тэгш эрх, харилцан ашигтай байх зарчмыг бататгах, гадаадын болон колонийн ноёрхол, гадаадын булаан эзлэлтэд байгаа ард түмний өөрөө засан тохинох, тусгаар тогтнох эрхийг хэрэгжүүлэх, түүнчлэн улс гүрний үндэсний бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх нь нийгмийн дэвшил, хөгжилд дэмжлэг болж, тэгснээрээ эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд бүрэн тэгш байдлыг хангахад дөхөм болохыг бататгаж;

эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэг адил бүхий л салбарт бүрэн оролцохыг аливаа улсын бүрэн бөгөөд цогц хөгжил, дэлхий нийтийн сайн сайхан, энх тайвны үйл шаардаж байгаад итгэн;

гэр бүлийн сайн сайхан болон нийгмийн хөгжилд эмэгтэйчүүдээс оруулж байгаа бөгөөд одоо хүртэл бүрэн хүлээн зөвшөөрөөгүй үлэмж хувь нэмэр, эх хүний нийгмийн ач холбогдол, гэр бүлд болон хүүхэд хүмүүжүүлэхэд эцэг болон эхийн гүйцэтгэх үүргийг харгалзан, үр удмаа залгамжлуулахад эмэгтэйчүүдийн үүрэг тэднийг алагчилах үндэс болохгүй, харин хүүхэд өсгөн хүмүүжүүлэхэд эрэгтэй, эмэгтэйчүүд болон нийгэм бүхэлдээ хариуцлагыг хуваалцах ёстой гэдгийг ухамсарлаж;

эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд бүрэн тэгш байдал тогтоохын тулд нийгэм болон гэр бүлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн уламжлалт үүрэгт өөрчлөлт оруулах шаардлагатайг хүлээн зөвшөөрч;

эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах тухай тунхаглалд заасан зарчмыг хэрэгжүүлэх болон энэ зорилгоор ийнхүү алагчилахын бүх хэлбэр, илрэлийг устгахад шаардлагатай арга хэмжээг батлахыг зорин;

дор дурдсан зүйлийг тохиролцов:

I ХЭСЭГ

1 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн зорилгоор “эмэгтэйчүүдийг алагчилах” гэсэн нэр томьёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ.

2 дугаар зүйл

Оролцогч улсууд эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг буруушаан, эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах бодлогыг зохистой бүхий л аргаар нэн даруй хэрэгжүүлэхээр тохиролцож, энэхүү зорилгоор дараахь арга хэмжээг авна:

(a) эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн зарчмыг үндэсний үндсэн хуулиндаа буюу зохих бусад хууль тогтоомждоо тусгаагүй бол, ийнхүү тусгаж, энэ зарчмыг хууль болон бусад зохистой аргаар хэрэгжүүлэхийг хангах;

(b) эмэгтэйчүүдийг алагчилах аливаа үзлийг хориглосон зохих хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээ, шаардлагатай тохиолдолд шийтгэх арга хэмжээг батлах;

(c) эрэгтэйчүүдтэй тэгш байх үндсэн дээр эмэгтэйчүүдийн эрхийг хуулиар хамгаалах, тухайн улсын эрх бүхий шүүх, төрийн бусад байгууллагаар дамжуулан алагчилах аливаа үйлдлээс эмэгтэйчүүдийг үр нөлөөтэй хамгаалахыг хангах;

(d) эмэгтэйчүүдийг алагчилах аливаа үйлдэл, үйл ажиллагаанаас татгалзах, төрийн байгууллага, алба энэхүү үүргийн дагуу ажиллахыг хангах;

(e) аливаа хүн, байгууллага буюу аж ахуйн нэгжийн зүгээс эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгахад чиглэсэн зохистой бүх арга хэмжээг авах;

(f) эмэгтэйчүүдийг алагчилсан хууль, зохицуулалт, заншил, дадлыг өөрчлөх буюу хүчингүй болгох талаар зохистой бүх арга хэмжээ, үүний дотор хууль тогтоох арга хэмжээг авах;

(g) эмэгтэйчүүдийг алагчилсан эрүүгийн бүх заалтыг хүчингүй болгох.

3 дугаар зүйл

Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй эрх тэгш байх үндсэн

дээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэх баталгааг олгох зорилгоор тэдний бүрэн хөгжил, дэвшлийг хангахын тулд бүхий л салбарт, тухайлбал, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авна.

4 дүгээр зүйл

1.Оролцогч улсаас эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг de facto түргэтгэхэд чиглэсэн түр тусгай арга хэмжээг энэхүү Конвенцид тодорхойлсны дагуу алагчилал хэмээн үзэхгүй. Гэвч энэ нь аливаа байдлаар тэгш бус буюу ялгамжтай хэм хэмжээг үүсгэх ёсгүй бөгөөд адил боломж, тэгш хандлагыг тогтоох зорилт биелэгдмэгц дээрх арга хэмжээг зогсооно.

2. Оролцогч улсаас эхчүүдийг хамгаалахад чиглэсэн тусгай арга хэмжээ, түүний дотор энэхүү Конвенцид заасан арга хэмжээг батлахыг алагчилал хэмээн үзэхгүй.

5 дугаар зүйл

Оролцогч улсууд дараахь зохистой бүх арга хэмжээг хэрэгжүүлнэ:

(a) аль нэг хүйсийг доорд, эсхүл дээрд үзэх, эсхүл эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүргийн талаархи хэвшсэн үзэлд тулгуурласан хохиролтой үйл ажиллагаа, заншил болон бусад бүх дадлыг устгах зорилгоор эрэгтэй, эмэгтэйчүүдийн зан төлөвийн нийгэм, соёлын хэв шинжийг өөрчлөх;

(b) гэр бүлийн боловсролд эх хүн байхыг нийгмийн үүрэг хэмээн зөвөөр ойлгох, хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэйчүүд хамтын хариуцлагыг хүлээн зөвшөөрөхийг хангах, бүх тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих.

6 дугаар зүйл

Оролцогч улсууд эмэгтэйчүүдийг худалдах, тэднийг биеийг үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээг авна.

II ХЭСЭГ

7 дугаар зүйл

Оролцогч улсууд тухайн улсын улс төр, олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах үүднээс зохистой бүхий л арга хэмжээг авна, тухайлбал, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил нөхцөлд дараахь эрхээр хангана:

(a) бүх сонгууль, ард нийтийн санал хураалтад санал өгөх болон нийтээр

сонгох бүх байгууллагад сонгогдох;

(b) төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, төрийн алба хаах, түүнчлэн төрийн захиргааны бүх түвшинд үүрэг гүйцэтгэх;

(c) тухайн улсын олон нийтийн болон улс төрийн амьдралтай холбогдол бүхий төрийн бус байгууллага, нийгэмлэгэд оролцох.

8 дугаар зүйл

Оролцогч улсууд эмэгтэйчүүдийг аливаа хэлбэрээр алагчилахгүйгээр эрэгтэйчүүдтэй адил нөхцөлд олон улсын хэмжээнд өөрийн засгийн газрыг төлөөлөх, олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох боломжоор хангах зохистой бүх арга хэмжээг авна.

9 дүгээр зүйл

1. Оролцогч улсууд иргэний харьяалалтай болох, түүнийг өөрчлөх буюу хэвээр хадгалах асуудлаар эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй тэгш эрх олгоно. Тухайлбал, оролцогч улс эмэгтэйчүүд гадаадын иргэнтэй гэрлэх, гэрлэлтийн хугацаанд нөхөр нь иргэний харьяаллаа өөрчлөхөд эхнэрийнх нь иргэний харьяаллыг шууд өөрчлөхгүй байх, мөн түүнийг иргэний харьяалалгүй болгохгүй байх, эсхүл нөхрийнх нь иргэний харьяаллыг авахыг албадахгүй байхыг хангана.

2. Оролцогч улсууд хүүхдийн иргэний харьяаллын тухайд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй тэгш эрх олгоно.

III ХЭСЭГ

10 дугаар зүйл

Оролцогч улсууд боловсролын салбарт эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй тэгш эрхээр хангахын тулд тэднийг алагчилах үзлийг устгах зохистой бүх арга хэмжээг авна, тухайлбал, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр:

(a) мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа олгох, сурч боловсрох, хот хөдөөгийн бүх шатны боловсролын байгууллагад суралцаж, диплом авах адил нөхцөл, энэхүү тэгш байдлыг сургуулийн өмнөх, ерөнхий, техникийн, мэргэшлийн болон техникийн дээд боловсрол, түүнчлэн мэргэжлийн сургалтын бүх төрөлд хангана;

(b) сургалтын адил хөтөлбөр, адил шалгалт, адил мэргэжлийн түвшин бүхий багш бүрэлдэхүүн, адил хичээлийн байр, адил чанар бүхий тоног төхөөрөмжтэй байх;

(c) эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүргийн тухай хэвшсэн аливаа номлолыг

сургалтын бүх шат, хэлбэрт устгах, энэ зорилгод хүрэхэд дөхөм болох хамтарсан болон сургалтын бусад төрлийг хөхиүлэн дэмжих, тухайлбал сурах бичиг, сургуулийн хөтөлбөрийг хянан өөрчлөх болон сургах арга зүйг шаардлагад тохируулан өөрчлөх;

(d) тэтгэлэг болон сургалтын бусад тэтгэмж авах адил боломж;

(e) үргэлжилсэн боловсролын хөтөлбөр, түүний дотор ялангуяа эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын аливаа зөрүүг аль болох богино хугацаанд багасгахад чиглэсэн насанд хүрэгсдийн болон бичиг үсэгт тайлах хөтөлбөрт хамрагдах адил боломж;

(f) эмэгтэй сурагчдын сургууль завсардалтын түвшинг бууруулах, сургуулиа дүүргээгүй охид, эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөр боловсруулах;

(g) спорт болон биеийн тамирын сургалтад идэвхтэй оролцох адил боломж;

(h) гэр бүлийн эрүүл мэнд, сайн сайхныг хангахад туслах тусгай боловсролын мэдээлэл, түүний дотор гэр бүл төлөвлөлтийн талаархи мэдээлэл, зөвлөгөө өгөх.

11 дүгээр зүйл

1. Оролцогч улсууд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийн салбарт эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгахын тулд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш эрхээр хангах зорилгоор зохистой бүх арга хэмжээг авна. Эдгээр эрх нь, тухайлбал:

(a) хүн бүрийн салшгүй эрх болох хөдөлмөрлөх эрх;

(b) хөдөлмөр эрхлэх тэгш боломжоор хангуулах, түүний дотор ажлын сонгон шалгаруулалтын адил шалгууртай байх эрх;

(c) мэргэжил, ажлын төрлийг чөлөөтэй сонгох, албан тушаал дэвших, ажлын баталгаатай байх, ажлын бүхий л тэтгэмж, нөхцлийг эдлэх, түүнчлэн мэргэжлийн сургалт болон давтан сургалтад хамрагдах, түүний дотор дагалдан сурах, мэргэжил дээшлүүлэх болон давтан суралцах эрх;

(d) тэгш шан хөлс, түүний дотор тэтгэмж эдлэх, адил үнэлгээтэй ажлын хувьд тэгш хандах, түүнчлэн ажлын чанарыг адил үнэлүүлэх эрх;

(e) нийгмийн баталгаатай байх, ялангуяа тэтгэвэрт гарах, ажилгүй болох, өвчлөх, тахир дутуу болох, өндөр настай болох хийгээд хөдөлмөрийн чадвараа алдах бусад тохиолдолд, түүнчлэн цалинтай амралт авах эрх;

(f) эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрлөх аюулгүй нөхцөлд ажиллах, түүний дотор үр удмаа залгамжлуулах үүргээ хамгаалах эрх.

2. Гэрлэлтийн, эсхүл хүүхэд төрүүлсэн байдалд үндэслэн эмэгтэйчүүдийг алагчилах үзлээс урьдчилан сэргийлэх, тэдний хөдөлмөрлөх эрхийг хангах

үүднээс оролцогч улс зохистой арга хэмжээ авна:

(a) жирэмсэн, эсхүл жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөөнд байгааг үндэслэн ажлаас халах, ажлаас халахад гэрлэлтийн байдлаар алагчилахыг хориглож, шийтгэл оногдуулна;

(b) ажлын байр, албан тушаал, нийгмийн тэтгэмжийг нь хадгалан жирэмсний болон хүүхэд төрүүлэх чөлөөг цалинтай, эсхүл түүнтэй дүйх хэмжээний нийгмийн тэтгэмжтэй олгох;

(c) эцэг эхэд гэр бүлийн үүргээ ажлын хариуцлага, олон нийтийн амьдралд оролцохтой хослуулах бололцоог олгохын тулд тухайлбал, хүүхэд асрах сүлжээг байгуулах, хөгжүүлэх замаар шаардлага бүхий нийгмийн туслах үйлчилгээг бий болгохыг хөхиүлэн дэмжих;

(d) жирэмсэн эмэгтэйчүүдэд хортой болох нь нотлогдсон ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийг жирэмсэн байх хугацаанд нь онцгойлон хамгаалах.

3. Энэхүү зүйлд заасан эрхийг хамгаалах хууль тогтоомжийг шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээнд үе үе хянаж, шаардлагатай тохиолдолд өөрчлөх, хүчингүй болгох буюу өргөтгөнө.

12 дугаар зүйл

1. Оролцогч улсууд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүдийг алагчилахыг устгахын тулд гэр бүл төлөвлөлтийг оролцуулан эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зохистой бүх арга хэмжээг авна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна оролцогч улсууд эмэгтэйчүүдийг жирэмсэн, төрөх, төрсний дараахь үед зохих үйлчилгээгээр хангаж, шаардлагатай тохиолдолд төлбөргүй үйлчилгээ үзүүлж, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй үед нь хүрэлцэхүйц хоол тэжээлээр хангана.

13 дугаар зүйл

Оролцогч улсууд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр эдийн засаг, нийгмийн амьдралын бусад салбарт эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгахын тулд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш эрхээр хангах зорилгоор зохистой бүх арга хэмжээг авна. Эдгээр эрх нь, тухайлбал:

(a) гэр бүлийн тэтгэмж авах эрх;

(b) банкны зээл авах, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах болон бусад хэлбэрээр санхүүгийн зээл авах эрх;

(c) амралт, чөлөөт цагийн арга хэмжээ, спорт болон соёлын амьдралын бүх салбарт оролцох эрх.

14 дүгээр зүйл

1. Оролцогч улсууд хөдөө нутгийн эмэгтэйчүүдийн өмнө тулгарч буй онцлог асуудал болон тэднээс гэр бүлийнхээ эдийн засгийн амьдралд гүйцэтгэж буй чухал үүрэг, түүний дотор аж ахуйн таваарын бус салбарт гүйцэтгэж буй ажлыг анхааран үзэж, хөдөө нутгийн эмэгтэйчүүдийн хувьд энэхүү Конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх талаар зохистой бүх арга хэмжээг авна.

2. Оролцогч улсууд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр хөдөө нутагт эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах үүднээс эмэгтэйчүүд хөдөө нутгийн хөгжилд оролцож, түүнээс ашиг хүртэх талаар зохистой бүх арга хэмжээг авч, тэднийг дараахь эрхээр хангана:

(a) хөдөө нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх түвшинд оролцох;

(b) эрүүл мэндийн хангалттай үйлчилгээ хүртэх, түүний дотор гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ авах;

(c) нийгмийн хангамжаас шууд хүртэх;

(d) албан болон албан бус сургалт, боловсролын бүх хэлбэрт хамрагдах, түүний дотор бичиг үсэгт тайлагдах, мөн inter alia, техникийн ур чадвараа дээшлүүлэх үүднээс хамтын нийгэмлэгийн буюу өргөтгөсөн үйлчилгээнд хамрагдах;

(e) хөдөлмөр эрхлэх, эсхүл хувиараа хөдөлмөрлөх замаар эдийн засгийн тэгш боломж хүртэхийн тулд өөртөө туслах бүлэг болон хоршоо байгуулах;

(f) хамтын нийгэмлэгийн бүх үйл ажиллагаанд оролцох;

(g) хөдөө аж ахуйн зээл, зээллэг, борлуулалтын механизм, зохих технологийг хүртэх, газар болон газар тариалангийн шинэтгэл, түүнчлэн газар сэлгэн суурьших төлөвлөгөөнд тэгш оролцох;

(h) амьдралын зохих нөхцлөөр, ялангуяа орон сууц, ариун цэвэр, цахилгаан болон усан хангамж, тээвэр, харилцаа холбооны тухайд хангагдах.

IV ХЭСЭГ

15 дугаар зүйл

1. Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд хуулийн өмнө эрэгтэйчүүдтэй тэгш байх эрх олгоно.

2. Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд иргэний харилцаанд эрэгтэйчүүдтэй тэгш эрх зүйн чадамж, түүнийг хэрэгжүүлэх тэгш боломж олгоно. Тухайлбал, гэрээ байгуулах болон эд хөрөнгө захиран зарцуулах тэгш эрхийг олгож, шүүх, тусгай шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд тэдэнд тэгш хандана.

3. Оролцогч улсууд эмэгтэйчүүдийн эрх зүйн чадамжийг хязгаарлахад чиглэсэн хүчин төгөлдөр бүх гэрээ болон иргэний харилцааны бусад баримт бичгийг хүчин төгөлдөр бус хэмээн тооцохоор тогтоно.

4. Оролцогч улсууд хүмүүсийн шилжих хөдөлгөөн, түр болон байнга оршин суух газраа сонгох эрх чөлөөтэй холбогдох хууль тогтоомжийн хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эрх олгоно.

16 дугаар зүйл

1. Оролцогч улсууд гэрлэлт, гэр бүлийн харилцааны бүх асуудлаар эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах зохистой бүх арга хэмжээ авах бөгөөд, тухайлбал, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр доорхи эрхээр хангана:

(a) гэрлэх тэгш эрх;

(b) гэрлэх хүнээ чөлөөтэй сонгох болон чөлөөтэй, бүрэн зөвшөөрсний үндсэн дээр гэрлэх адил эрх;

(c) гэрлэлтийн туршид болон гэрлэлтийг цуцлуулахад адил эрх, үүрэг;

(d) гэрлэлтийн байдлаас үл хамаарч эцэг эх хүүхэдтэй холбоотой асуудлаар адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд бүх тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина;

(e) хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх хоорондын зайг чөлөөтэй бөгөөд хариуцлагатай шийдвэрлэх, эдгээр эрхийг хэрэгжүүлэх боломж олгох мэдээлэл, боловсрол, аргыг олж авах адил эрх;

(f) хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих, үрчлэх, эсхүл үндэсний хууль тогтоомжоор зохицуулсан төсөөтэй харилцаанд адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд бүх тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина;

(g) овог, ажил, мэргэжлээ сонгохыг оролцуулан эхнэр, нөхрийн хувьд адил хувийн эрх;

(h) хөрөнгийг үнэгүй болон төлбөртэйгээр өмчлөх, эзэмших, захирах, ашиглах, захиран зарцуулахын тухайд эхнэр, нөхрийн тэгш эрх.

2. Хүүхдэд сүй тавих болон хүүхдийг гэрлүүлэх нь эрх зүйн үр дагаваргүй бөгөөд гэрлэх насны доод хязгаарыг тогтоох, гэрлэлтийг заавал албан ёсны бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааг, түүний дотор хууль тогтоох арга хэмжээг авна.

V ХЭСЭГ

17 дугаар зүйл

1. Энэхүү Конвенцийн хэрэгжилтэд гарсан дэвшлийг хэлэлцэх зорилгоор

ёс суртахууны эрхэм дээд чанарыг эзэмшсэн, Конвенцид хамаарах асуудлаар мэргэшсэн, Конвенцийг хүчин төгөлдөр болох үед арван найман мэргэжилтнээс, Конвенцийг гучин тав дахь улс соёрхон батлах буюу нэгдэн орсны дараа хорин гурван мэргэжилтнээс бүрдсэн Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хороог (цаашид хороо гэж нэрлэнэ) байгуулна. Эдгээр мэргэжилтнийг Конвенцид оролцогч улсууд өөрийн иргэдээс сонгох бөгөөд тэд өөрсдийн нэрийн өмнөөс үүргээ гүйцэтгэнэ. Чингэхдээ газар зүйн тэгш хуваарилалт болон соёл иргэншлийн ялгаатай хэлбэр, эрх зүйн үндсэн тогтолцоонуудын төлөөлөлд анхаарна.

2. Хорооны гишүүдийг оролцогч улсуудаас нэрийг нь дэвшүүлсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтаас нууцаар санал хураах журмаар сонгоно. Оролцогч улс бүр өөрийн иргэдээс нэг хүний нэрийг дэвшүүлнэ.

3. Анхны сонгуулийг энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дараа явуулна. Сонгууль бүрийг явуулахаас наад зах нь гурван сарын өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч улсуудад захидал илгээж, дэвшүүлж байгаа хүнийхээ нэрийг хоёр сарын дотор илгээхийг санал болгоно. Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшигдсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг цагаан толгойн үсгийн дарааллаар гаргаж, тэдгээрийн нэрийг дэвшүүлсэн улсыг хамт тэмдэглэн оролцогч улсуудад илгээнэ.

4. Хорооны гишүүдийн сонгуулийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд Ерөнхий нарийн бичгийн даргаас зарлан хуралдуулах оролцогч улсуудын хуралдаан дээр явуулна. Оролцогч улсуудын гуравны хоёр нь хуралдах ирцийг бүрдүүлэх бөгөөд санал хураахад байлцаж, саналаа өгсөн оролцогч улсуудын төлөөлөгчдийн хамгийн олон болон дийлэнхи олонхийн саналыг авсан нэр дэвшигчдийг хорооны гишүүнээр сонгогдсонд тооцно.

5. Хорооны гишүүдийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Гэхдээ анхны сонгуулиар сонгогдсон есөн гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жилийн дараа дуусах бөгөөд анхны сонгуулийг явуулж дуусмагц дээрх есөн гишүүний нэрийг хорооны дарга шодож тогтооно.

6. Гучин тав дахь улс Конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн орсны дараа энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийн заалтын дагуу Хороонд таван гишүүнийг нэмж сонгоно. Эдгээр нэмж сонгогдсон таван гишүүний хоёрынх нь бүрэн эрхийн хугацаа хоёр жилийн дараа дуусах бөгөөд дээрх хоёр гишүүний нэрийг хорооны дарга шодож тогтооно.

7. Тохиолдлоор суларсан орон тоог нөхөхийн тулд тухайн орон тоонд ажиллаж байсан мэргэжилтний нэрийг дэвшүүлсэн оролцогч улс өөрийн иргэдээс өөр нэг мэргэжилтнийг томилж, хороогоор батлуулна.

8. Хорооны хүлээх хариуцлагын ач холбогдлыг харгалзан Ерөнхий

Ассамблейгаас баталсны дагуу хорооны гишүүд Нэгдсэн Үндэстний Байгууллагын эх үүсвэрээс Ерөнхий Ассамблейгаас тогтоосон нөхцөл, журмын дагуу цалин авна.

Энэхүү Конвенцийн дагуу хороо үүргээ үр нөлөөтэй гүйцэтгэх үүднээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга шаардлагатай ажилтан, хэрэгслээр хангана.

18 дугаар зүйл

1. Оролцогч улсууд энэхүү Конвенцийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор авсан хууль тогтоомж, шүүх эрх мэдэл, захиргааны болон бусад арга хэмжээ, энэ талаар гарсан дэвшлийн тухай тайланг хорооогоор хэлэлцүүлэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад дор заасан хугацаанд хүргүүлж байх үүрэгтэй:

(a) тухайн улсын хувьд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор;

(b) түүний дараа наад зах нь дөрвөн жил тутам болон хороо шаардсан тухай бүр.

2. Энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйл, бэрхшээлийн талаар тайланд дурдаж болно.

19 дүгээр зүйл

1. Хороо үйл ажиллагааны дотоод журмаа батална.

2. Хороо албан тушаалтнуудаа хоёр жилийн хугацаагаар сонгоно.

20 дугаар зүйл

1. Энэхүү Конвенцийн 18 дугаар зүйлийн дагуу ирүүлсэн тайланг хэлэлцэх зорилгоор хороо гол төлөв жил бүр хоёр долоо хоногоос дээшгүй хугацаагаар хуралдана.

2. Хорооны хуралдааныг гол төлөв Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд, эсхүл хорооноос тогтоосон аливаа тохиромжтой газар хийнэ.

21 дүгээр зүйл

1. Хороо нь Эдийн засаг, нийгмийн зөвлөлөөр дамжуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд үйл ажиллагааныхаа талаар жил бүр тайлагнах бөгөөд оролцогч улсуудаас хүлээж авсан тайлан, мэдээллийг шалгасны үндсэн дээр санал болон ерөнхий зөвлөмж гаргаж болно. Эдгээр санал, ерөнхий зөвлөмжийг оролцогч улсаас тайлбар

гаргасан бол уг тайлбарын хамт хорооны тайланд оруулна.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга Хорооны тайланг Эмэгтэйчүүдийн эрх зүйн байдлын комиссоос мэдээлэл авахаар хүргүүлнэ.

22 дугаар зүйл

Төрөлжсөн байгууллагууд үйл ажиллагааныхаа хүрээнд хамаарах энэхүү Конвенцийн заалтын хэрэгжилтийг хэлэлцэхэд төлөөлөгчөө илгээх эрхтэй. Үйл ажиллагааных нь хүрээнд хамаарах салбар дахь Конвенцийн хэрэгжилтийн талаар тайлагнахыг хороо төрөлжсөн байгууллагуудаас шаардаж болно.

VI ХЭСЭГ

23 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн аливаа заалт:

(a) оролцогч улсын хууль тогтоомжид, эсхүл

(b) тухайн улсад хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын аливаа бусад конвенц, гэрээ, хэлэлцээрт тусгасан байж болох эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангахад илүү дөхөм үзүүлэх аливаа заалтад нөлөөлөхгүй.

24 дүгээр зүйл

Оролцогч улсууд энэхүү Конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэгдсэн шаардлагатай бүх арга хэмжээг үндэсний түвшинд батлана.

25 дугаар зүйл

1. Энэхүү Конвенц бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг энэхүү Конвенцийн хадгалагчаар томилно.

3. Энэхүү Конвенцийг соёрхон батална. Соёрхон батласан батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

4. Энэхүү Конвенц бүх улс нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орсон хэмээн үзнэ.

26 дугаар зүйл

1. Энэхүү Конвенцийг хянаж өөрчлөх тухай хүсэлтийг аливаа оролцогч

улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр хэдийд ч гаргаж болно.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей ийм төрлийн хүсэлттэй холбогдуулж авах арга хэмжээ байгаа бол уг арга хэмжээний талаар шийдвэр гаргана.

27 дугаар зүйл

1. Энэхүү Конвенц нь хорь дахь соёрхон батласан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь соёрхон батласан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг хадгалуулсны дараа энэхүү Конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдөр энэхүү Конвенц хүчин төгөлдөр болно.

28 дугаар зүйл

1. Конвенцийг соёрхон батлах буюу нэгдэн орохдоо оролцогч улсаас хийсэн тайлбарын эх бичвэрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авч, бүх улсад хүргүүлнэ.

2. Энэхүү Конвенцийн зорилго, зорилтод харшилсан тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.

3. Тайлбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад зохих ёсоор мэдэгдэж хэдийд ч буцаан авч болох бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга энэ тухай бүх улсад мэдэгдэнэ. Тайлбарыг буцаан авах тухай мэдэгдэл нь түүнийг хүлээн авсан өдөр хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

1. Энэхүү Конвенцийг тайлбарлах буюу хэрэглэх талаар оролцогч хоёр буюу түүнээс дээш улсын хооронд үүссэн маргааныг хэлэлцээний журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр арбитраар шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Ийнхүү хүсэлт гаргаснаас хойш зургаан сарын дотор талууд арбитрын бүрэлдэхүүний талаар тохиролцож чадахгүй бол аль нэг тал маргааныг Олон улсын шүүхэд түүний дүрмийн дагуу хүсэлт гарган шилжүүлж болно.

2. Аливаа оролцогч улс энэхүү Конвенцид гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах эсхүл түүнд нэгдэн орохдоо энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт түүний хувьд үйлчлэхгүйг мэдэгдэж болно. Тийм тайлбар хийсэн аливаа

оролцогч улстай холбоотойгоор оролцогч бусад улсын хувьд энэ хэсгийн заалт үйлчлэхгүй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн аливаа оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж уг тайлбарыг хэдийд ч буцааж болно.

30 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн араб, хятад, англи, франц, орос болон испани хэлээр үйлдсэн эх бичвэр нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦИЙН МОНГОЛ УЛСЫН ЭЭЛЖИТ НАЙМ БА ЕСДҮГЭЭР ИЛТГЭЛИЙН ТАЛААРХ АЖИГЛАЛТЫН ДҮГНЭЛТҮҮД

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦ

МОНГОЛ УЛСЫН ЭЭЛЖИТ НАЙМ БА ЕСДҮГЭЭР ИЛТГЭЛИЙН ТАЛААРХ АЖИГЛАЛТЫН ДҮГНЭЛТҮҮД*

1. Тус Хороо Монгол Улсын найм ба есдүгээр ээлжит нэгтгэсэн илтгэлийг (CEDAW/C/MNG/8-9) 2016 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 138, 1382 дугаар хуралдаануудаараа (CEDAW/C/SR.1381 ба 1382-ыг үзэх) хэлэлцэв. Хорооноос тавьсан асуултууд нь CEDAW/C/MNG/Q/8-9, Монгол Улсын Засгийн газрын хариултууд нь CEDAW/C/MNG/Q/8-9/Add.1 зэрэг бичиг баримтын эх үүсвэрт хадгалагдсан болно.

A. Оршил хэсэг

2. Хороо нь Гишүүн орон найм ба есдүгээр ээлжит нэгтгэсэн илтгэлээ ирүүлсэнд талархал илэрхийлж байна. Түүнчлэн, чуулганы өмнөх ажлын хэсгээс өгсөн асуултуудад хариулт өгснийг мөн талархан хүлээн авсан болно. Улмаар хэлэлцүүлгийн үеэр төлөөлөгчдийн хийсэн танилцуулга болон Хорооны гишүүдээс тавьсан асуултуудад нэмэлт тодруулга, хариултуудыг өгснийг мөн талархан хүлээн авав.

3. Хороо нь Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга хатагтай Гочоогийн Нарангэрэлээр ахлуулсан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, спортын яам, Хөдөлмөрийн яам, Хууль зүйн яам болон Женев дэх НҮБ-ын дэргэд Монгол Улсаас суугаа Байнгын төлөөлөгчийн газрын төлөөлөл бүхий төлөөлөгчдийг сайшаан хүлээн авав.

B. Ахицтай асуудлууд

4. Хороо нь долдугаар ээлжит илтгэл (CEDAW/C/MNG/7)-ээ 2008 онд хэлэлцүүлснээс хойшхи хугацаанд Гишүүн орон дараах хуулиудыг баталж, эрхзүйн шинэчлэл хийх хүрээнд олсон ололт амжилтуудыг нь сайшаав. Үүнд:

(a) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016;

(b) Хүүхэд асрах үйлчилгээний тухай хууль, 2015;

** Хорооны 63 дугаар хуралдаанаар батлагдсан (2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 04-ний өдөр).*

(c) Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, үүнд гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг болгон хуульчилж, янз бүрийн үндэслэлээр ялгаварлан гадуурхах явдлыг хориглосон байна, 2015;

(d) Хохирогч, гэрчийг хамгаалах тухай хуулийг баталж хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн охид, эмэгтэйчүүдийг хамгаалах орчныг бүрдүүлсэн, 2013;

(e) Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012;

(f) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011;

5. Хороо нь эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах явдлыг устгах, эрхийг нь баталгаажуулах явцыг түргэтгэх зорилгоор дараах бичиг баримтуудыг батлах замаар бодлогын орчныг сайжруулах чиглэлээр Гишүүн орны гаргаж буй хүчин чармайлтыг сайшаав. Үүнд:

(a) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (2013 - 2016), 2013;

(b) Эх, нярайн эрүүл мэндийн стратеги (2011 - 2015).

6. Хороо Гишүүн орон нь өмнөх илтгэлээ хэлэлцүүлснээс хойшхи хугацаанд дараах олон улсын баримт бичгүүдийг соёрхон баталж, нэгдэн орсныг мөн сайшаав. Үүнд:

(a) Эрүүдэн Шүүх Болон Бусад Хэлбэрээр Хэрцгий, Хүнлэг Бусаар Буюу Хүний Нэр Төрийг Доромжлон Харьцаж Шийтгэхийн Эсрэг Конвенцийн Нэмэлт Протокол, 2015;

(b) Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай Олон улсын Конвенц, 2015;

(c) Цаазын ялыг устгахад чиглэсэн Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Хоёрдугаар Нэмэлт Протокол, 2012;

(d) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц, 2009.

С. Ерөнхий асуудлууд болон зөвлөмжүүд

Улсын Их Хурал

7. Хороо нь энэхүү Конвенцийн бүрэн дүүрэн хэрэгжилтийг хангуулахад хууль эрх зүйн эрх мэдэл чухал ач холбогдолтой болохыг (2010 онд болсон Конвенцийн Хорооны 45 дугаар чуулганаар баталсан Парламентчидтай харилцах харилцаа холбооны талаарх мэдэгдлийг үзэх) онцлон тэмдэглэж байна. Хороо нь энэхүү Ажиглалтын дүгнэлтүүдийн хэрэгжилтийг одоогоос эхлэн Конвенцийн хэрэгжилтийн талаарх дараагийн ээлжит илтгэлийг хүргүүлэх хүртэлх хугацаанд хангуулж ажиллахыг Улсын Их Хуралд санал болгож байна.

Үндсэн хууль ба эрх зүйн орчин

8. Хороо нь Гишүүн орон жендэрийн ялгаварлан гадуурхах явдлыг хориглоход чиглэсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль баталсныг (2011) талархан хүлээн авав. Гэвч дараах асуудалд анхаарал хандуулж байна. Үүнд:

(a) Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх, хариуцлага тооцоход зохистой нөөц хангалтгүй байна;

(b) Засгийн газрын янз бүрийн түвшинд энэхүү Конвенц, Нэмэлт Протоколд тунхагласан эмэгтэйчүүдийн эрхийн тухай болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлын зарчим болон Хорооноос өгсөн ерөнхий зөвлөмжүүдийн талаарх мэдлэг хангалтгүй байна;

(c) Эмэгтэйчүүдийн хувьд шүүх засаглал хэр хүртээмжтэй байгаа болон энэхүү Конвенцийн заалтууд шууд хэрэглэгдсэн шүүх хэргийн тохиолдол байгаа эсэх талаар мэдээлэл хомс байна;

(d) Эмэгтэйчүүд, нэн ялангуяа хөдөө орон нутгийн болон нийгмийн эмзэг бүлэгт хамаарах эмэгтэйчүүд энэхүү Конвенцийн дагуу эдлэх эрхийнхээ талаар мэддэггүй, улмаар өөрсдийнхөө эрхийг хамгаалахад шаардлагатай мэдээллээр хомс байна.

9. Хороо нь дараах арга хэмжээг нэн даруй авахыг Гишүүн орноос шаардаж байна:

(a) Үндсэн хууль, энэхүү Конвенцид тунхагласан эмэгтэйчүүдийн эрхэд нийцүүлэн, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хариуцлага тооцох хүчирхэг механизмыг бүрдүүлэх, хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн хөрөнгө нөөцийг зохистойгоор хуваарилах;

(b) Засгийн газрын янз бүрийн түвшинд, ялангуяа хууль цаазын байгууллагууд энэхүү Конвенц, Нэмэлт Протокол болон Хорооноос өгсөн Ерөнхий Зөвлөмжүүд нь хууль тогтоомж, шүүхийн шийдвэр болон жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах бодлогын үндэслэл байх ёстой гэдэг талаар хангалттай мэдээлэлтэй байж, хэрэглэдэг байх явдлыг хангана;

(c) Энэхүү Конвенцийн дагуу эдлэх эрхийнх нь талаар эмэгтэйчүүдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, зөрчигдсөн эрхээ нэхэмжлэхэд шаардлагатай боломжийг нь нэмэгдүүлэх болон бүх эмэгтэйчүүд, тэр дундаа хөдөөгийн эмэгтэйчүүдийг энэхүү Конвенц, Нэмэлт Протокол болон Хорооноос өгсөн Ерөнхий Зөвлөмжүүдийн талаарх мэдээллээр хангана.

Гомдлын механизмын хүртээмжтэй байдал

10. Хүний эрхийн Үндэсний Комисс нь жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлыг хүлээн авах, хянан үзэх болон энэхүү Конвенцийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх эрхтэй гэдгийг Хороо онцлон тэмдэглэж байна. Гэвч эмэгтэйчүүд, нэн ялангуяа хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүд шүүх ба эрх зүйн гомдлын механизмын хүртээмжийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байна. Түүнчлэн, энэхүү Конвенцийн болон хүний эрхийн олон улсын баримт бичгүүдийн хэрэгжилтэд үр дүнтэй хяналт шинжилгээ хийх явдал хангалтгүй байгаад сэтгэл зовниж байна.

11. Хороо дараах арга хэмжээ авахыг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Энэхүү Конвенцийн дагуу эдлэх эрхээ нэхэмжлэх чадавхитай болгохын тулд эмэгтэйчүүдийн эрх, эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх;

(b) Энэхүү Конвенцийн хэрэгжилтэд үр дүнтэй хяналт шинжилгээ хийхэд шаардлагатай хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн хөрөнгө нөөцөөр хангах замаар Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус байдлыг бэхжүүлэх;

(c) Нийт эмэгтэйчүүдийн эрхийг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд Хүний эрхийн Үндэсний Комисс, иргэний нийгмийн байгууллагууд болон холбогдох бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах.

Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний механизм

12. Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба буюу Гишүүн оронд эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний механизмын цөм нэгжийг 2014 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны бүтцэд шилжүүлж, хүний нөөц болон санхүүгийн хөрөнгө нөөцийн хувьд хорогдуулсан нь Гишүүн оронд Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад учруулна хэмээн Хороо санаа зовниж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2016)-г дурдахын сацуу, тэдгээрийн хэрэгжилтэд мониторинг хийх, хариуцлага тооцох механизмыг бүрдүүлээгүй байна. Түүнчлэн, Жендэрийн үндэсний хороо болон УИХ, иргэний нийгмийн хооронд эмэгтэйчүүдийн асуудлаарх хамтын ажиллагааны талаархи мэдээлэл дутмаг байгаад анхаарал хандуулж байна.

13. Хороо дараах арга хэмжээ авахыг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Энэхүү Конвенцийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа төвлөрөлийг сааруулах зарчмаар явуулахад нь хүний нөөцийн, техникийн

болон санхүүгийн хөрөнгө нөөцөөр хангах замаар Жендэрийн үндэсний хороог бэхжүүлэх;

(b) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2016)-нд тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэхэд гарч буй ахиц дэвшилд тогтмол үнэлгээ хийх зорилгоор хяналт шинжилгээ, үнэлгээний арга механизмыг бий болгох;

(c) Жендэрийн үндэсний хороо нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд УИХ, иргэний нийгэм, нэн ялангуяа эмэгтэйчүүдийн байгууллагуудтай хамтран ажиллах.

Түр тусгай арга хэмжээ

14. УИХ-ын сонгуульд улс төрийн намууд эмэгтэй нэр дэвшигчдийн квотыг доод тал нь 30 хувь байхаар тогтоосныг Хороо талархан хүлээн авав. Гэвч Гишүүн орон практик дээр энэ чиглэлээр түр тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тал дээр хангалттай ажиллахгүй байгаад Хороо сэтгэл зовниж байна.

15. Энэхүү Конвенцийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2004 онд батлагдсан Түр тусгай арга хэмжээний талаарх 25 дугаар Ерөнхий Зөвлөмжид заасанчлан, Хороо дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Түр тусгай арга хэмжээний талаарх концепцийн талаар төрийн албан хаагчид, бодлого боловсруулагчдын чадавхийг дээшлүүлэх, төр, улс төрийн амьдрал, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг эмэгтэйчүүд бага төлөөлөлтэй байгаа бүхий л салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг бодитойгоор хангахад чиглэсэн, тодорхой цаг хугацаатай болон квот тогтоосон зэрэг түр тусгай арга хэмжээнүүдийг баталж хэрэгжүүлэх;

(b) Түр тусгай арга хэмжээ хангалтгүй хэрэгжиж байгаагийн үндсэн шалтгааныг шийдвэрлэж, улсын болон хувийн салбарт тэдгээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжсэн хууль тогтоомжийг батлах.

Хэвшмэл ойлголт

16. Гэр бүл, нийгэм болон хэвлэл мэдээлэлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэж буй үүрэг хариуцлагын талаар эцгийн эрх давамгайлсан чиг хандлага, ялгаварлан гадуурхсан угшсан хэвшмэл ойлголт хэвээр байгаа нь гэр бүл, нийгэмд эмэгтэйчүүдийн дорой байдлыг гаруулж, улмаар

мэргэжил боловсролын сонголтод нь нөлөөлөх, төр, улс төрийн амьдралд тэдний оролцоог хязгаарлаж, хөдөлмөрийн зах зээл дээр тэгш бус оролцоог, мөн гэр бүлийн харилцаанд ч мөн тэгш бус статусыг бий болгож байгаад Хороо сэтгэл зовнисоор байна. Түүнчлэн, ялгаварлан гадуурхалтыг бий болгож буй хэвшмэл ойлголт нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн язгуур шалтгаан мөн гэдгийг дахин дурдахын сацуу Гишүүн орон нь уламжлал болсон сөрөг чиг хандлагыг өөрчлөх, арилгах талаар тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаад Хороо сэтгэл зовниж байгаагаа илэрхийлж байна.

17. Хороо дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Гэр бүл, нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлагын талаарх ялгаварласан хэвшмэл ойлголт, эцгийн ёс давамгайлсан чиг хандлагыг арилгахын тулд нийгмийн бүхий л түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүст чиглэсэн тууштай арга хэмжээ бүхий цогц стратегийг аливаа нэгэн саадгүйгээр гаргаж хэрэгжүүлэх;

(b) Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бодит тэгш байдлын талаарх ойлголтыг бэхжүүлэх, бүхий л салбарт, ялангуяа боловсролын тогтолцоонд онцгой анхаарал хандуулан, нийгэмд эмэгтэйчүүдийн талаар эерэг, хэвшмэл бус ойлголтыг нэмэгдүүлэх;

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

18. Монгол Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, гэр бүлийн болон охид, эмэгтэйчүүд, хүйсийн цөөнхийн эсрэг хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож, тухайн хохирогчтой эвлэрсэн гэх замаар буруутай этгээд ял шийтгэлээс зайлсхийдэг байсныг халсныг Хороо талархан хүлээн авч байна. Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл гэсэн нэр томъёог өргөжүүлж оруулсныг талархан хүлээн авлаа. Гэвч тус хуулийг батлуулах явц удаашралтай байгаад анхаарал хандуулж байна. Гишүүн оронд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тоо өндөр байгаад Хороо анхаарал хандуулж, холбогдох статистик тоо мэдээлэл дутмаг байгаад сэтгэл зовниж байна. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжийг цагдаагийн байгууллагад байгуулсан хэдий ч гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах төрийн мэдлийн цорын ганц байр байгаад Хороо анхаарал хандуулах ёстой гэж үзэж байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн хувьд тэдгээр хамгаалах байр нь хүртээмжгүй байгаагийн улмаас тэд зохих дэмжлэг туслалцаа, үйлчилгээ авч чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хохирогч эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ, эмзэг байдалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр цагдаагийн ажилтнууд, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулдаггүй байна.

19. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай 1992 оны 19 дүгээр Ерөнхий Зөвлөмжид дурдсанчлан, Гишүүн орныг дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг Хороо шаардаж байна. Үүнд:

(a) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг батлуулах явцыг яаравчлах, охид, эмэгтэйчүүдийн хүчирхийллээс сэргийлэх, шийдвэрлэх цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, хүчирхийллийн хохирогчдын хохирлыг барагдуулах, хамгаалах, буруутай этгээдүүдийг илрүүлэх, зохих ёсны шийтгэл оногдуулах зэрэг арга хэмжээг нэн даруй авах;

(b) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эрүүгийн хэрэг болгон хуульчилсан хууль тогтоомжийг хатуу чанд хэрэгжүүлэх, гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй журмуудын хэрэгжилтийг хангуулах ажилтнууд, шүүгч, прокурор, цагдаа зэрэг хууль сахиулах ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх албан ёсны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

(c) Хөдөө орон нутагт хамгаалах байр байгуулах, сэргээн засах үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа дээшлүүлэх замаар гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдэнд зохих туслалцаа үзүүлэх;

(d) Гэр бүлийн, бэлгийн болон эмэгтэйчүүдийн эсрэг бусад хэлбэрийн хүчирхийлэлтэй холбогдсон статистик тоо мэдээг нас болон хохирогч ба буруутай этгээдийн харилцаа хамаарлын задаргаатайгаар гаргах;

(e) Гэмт хэргийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд нөхөн сэргээх зохистой нөхцөлийг бүрдүүлэх.

Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөг

20. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудлаар салбар зөвлөлийг 2012 онд байгуулсныг Хороо онцлон тэмдэглэж байна. Гэвч Хороо дараах асуудалд анхаарал хандуулж байна. Үүнд:

(a) Ядуу өрхийн охид, тэдний гэр бүлийн гишүүд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж байгаагийн үндсэн шалтгааныг тогтоож шийдвэрлэх, хүний наймааны хохирогч болсон охид, эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдэнд

чиглэсэн нөхөн сэргээх үйл ажиллагаа хангалтгүй байгааг шийдвэрлэхэд одоогийн хэрэгжиж байгаа хууль тогтоомж, хөтөлбөрүүдийн санхүүгийн хөрөнгө нөөц хязгаарлагдмал байна;

(b) Хүн худалдаалахтай тэмцэх Үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдах явц удааширч байна.

(c) Охид, эмэгтэйчүүдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгтэй холбогдсон гомдлын тоо, мөрдөн байцаалт, шүүх болон ял оногдуулах үйл ажиллагаа, түүнчлэн хохирогчдод туслалцаа үзүүлэх, нөхөн сэргээх хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл хомс байна.

(d) Хүний наймааны хохирогчдыг эрт илрүүлэх, тэдэнд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй арга замуудын ач холбогдлын талаар шүүх, хууль сахиулах байгууллага, хилийн хяналтын болон нийгмийн ба эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.

(e) Биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний хэрэгцээнд нийцсэн хамгаалах байр байхгүй байгаа болон биеэ үнэлэхээс ангижрахыг хүсч буй эмэгтэйчүүдэд чиглэсэн нийгэмших хөтөлбөрүүд хангалтгүй байна.

21. Хороо нь дараах арга хэмжээ авахыг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Хүн худалдаалахын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, холбогдох хууль, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хуваарилагдсан санхүүгийн хөрөнгө нөөцийг нэмэгдүүлэх;

(b) Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэн даруй эцэслэн боловсруулж, батлах;

(c) Шүүх, хил хяналтын цагдаа, хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон эрүүл мэндийн ба нийгмийн ажилтнуудыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг эрт илрүүлэх, жендэрийн мэдрэмжтэй аргаар ажиллах чиглэлээр чадавхийг нь дээшлүүлэх;

(d) Охид, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийн гишүүдийн боловсрол ба эдийн засгийн боломжийг нэмэгдүүлснээр хүн худалдаалах гэмт хэргийн язгуур шалтгааныг шийдвэрлэх, ингэснээр тэдний хүн худалдаалагчдад мөлжлөгдөх эмзэг байдлыг бууруулах;

(e) Биеэ үнэлэх үзэгдлийг шийдвэрлэх цогц арга хэмжээ авах, биеэ үнэлэхээс салах хүсэлтэй эмэгтэйчүүдэд зориулсан хамгаалах байр, хямралын үед дэмжлэг үзүүлэх төв, тэднийг нийгэмшүүлэх хөтөлбөр, орлого олох боломжийг бүрдүүлэх, түүнчлэн биеэ үнэлэх үзэгдлийн эрэлтийг бууруулах арга хэмжээ авах;

(f) Охид, эмэгтэйчүүдийн наймаа, ялангуяа хүний наймаачдыг шүүсэн,

ял оногдуулсан хэрэг болон биеэ үнэлж буй эмэгтэйчүүдтэй холбогдсон цогц тоо мэдээ, мэдээллийг дараагийн ээлжит тайландаа оруулах.

Улс төр, нийгмийн амьдралд оролцох

22. Хороо, хэдийгээр төрийн алба болон шүүхийн байгууллагад эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэн, түүнчлэн намын жагсаалтаар эмэгтэй нэр дэвшигчдийн квот 30 хувьд хүрснийг талархан хүлээн авахын зэрэгцээ УИХ, шийдвэр гаргах түвшинд буюу улс төр, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцооны түвшин доогуур байгаад анхаарал хандуулахыг шаардаж байна. Энэ нь уламжлалт зан үйл, түр тусгайлсан арга хэмжээ хангалттай авахгүй байгаа, эмэгтэй нэр дэвшигчдийн чадавхи сул, кампанит ажлын санхүүжилт хомс, “нэр дэвшигчийн татвар”-аас улбаатай байна. Түүнчлэн, аймаг, нийслэлд эмэгтэй засаг дарга томилогдохгүй байгаад сэтгэл зовниж байна. Улмаар шинээр батлагдсан Сонгуулийн тухай хуулийн 11(5) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэр дундаа эмэгтэйчүүдийн санал өгөх эрх, сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байгаад Хороо сэтгэл зовниж байна.

23. Хороо нь Гишүүн оронд дараах зүйлийг зөвлөмж болгож байна. Үүнд:

(a) Нийгэм, улс төрийн амьдралын бүхий л салбар, түвшинд тэр дундаа Улсын Их Хурал, Засгийн газарт шийдвэр гаргах албан тушаалд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог дараах байдлаар нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

(b) Эмэгтэй нэр дэвшигчдийг сонгуулийн нэрсийн жагсаалт болон/буюу тойрогт өндөр санал авах явдлыг хангах замаар улс төрийн намуудын сонгуулийн нэрсийн жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчдийн 30%-ийн квотыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх;

(c) Кампанит ажлыг үр дүнтэй явуулах, санхүүжилт, улс төрийн сүлжээний хүртээмж болон хэвлэл мэдээлэл ашиглах талаар эмэгтэй нэр дэвшигчдийн чадавхийг дээшлүүлэх;

(d) Эмэгтэйчүүдийн улс төр, нийгмийн амьдрал дахь оролцооны талаарх Хорооны 23 дугаар Ерөнхий зөвлөмжид заасанчлан, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш үндсэн дээр төв ба орон нутгийн түвшинд шийдвэр гаргах албан тушаалд томилогдоход чиглэсэн сургалт, жендэрийн мэдрэмжтэй хөдөлмөр эрхлэлтийн болон түр тусгай зэрэг зорилтот арга хэмжээнүүдийг авах;

(e) Эмэгтэйчүүдийн хувьд томоохон саад тотгор болж буй нэр дэвшигчийн татвар хураамжийг арилгах;

(f) Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй тэгш үндсэн дээр улс төр, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, эрх тэгш, чөлөөтэйгээр болон ардчилсан зарчмын үндсэн дээр оролцох нь энэхүү Конвенцийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн шаардлагын тухай ойлголтыг дээшлүүлэхийн тулд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг оролцуулахын ач холбогдлын талаар улс төрчид, удирдагчид, сэтгүүлчид болон иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

(g) Аймаг, нийслэлийн засаг дарга зэрэг өндөр албан тушаалд эмэгтэйчүүдийг томилох арга хэмжээ авах;

(h) Сонгуулийн тухай хууль (2015)-д хөгжлийн бэрхшээлтэй иргэд, түүний дотор эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг хязгаарласныг нэн даруй цуцалж, уг хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээл нь ялгаварлан гадуурхалтын үндэслэл болохгүй байх явдлыг хангах;

Боловсрол

24. Хороо эмэгтэйчүүдийн дунд бичиг үсэг тайлагдалт өндөр байгаа болон бага, дунд боловсролд охидын хамрагдал өндөр байгааг талархан хүлээн авч байна. Гэвч дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай хэвээр байна. Үүнд:

(a) Боловсролын сургалтын хөтөлбөрт бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлууд тусгагдсан хэдий ч энэ нь жендэрийн зарчмыг тодорхой агуулаагүй байна;

(b) Сургууль, сургуулийн дотуур байранд бэлгийн хүчирхийлэл гарсаар байгаа бөгөөд энэ нь өсвөр насны жирэмслэлтийн тоог нэмэгдүүлсээр байна;

(c) Жирэмсэн охидыг сургуулиас албадан гаргаж, түүнчлэн албан ёсны боловсролын системд нэгтгэн хамруулах боломжийг тэдэнд олгохын оронд хувилбарт боловсролын хэлбэрийг хэрэгжүүлж байна;

(d) Хөгжлийн бэрхшээлтэй охидыг хамруулсан, хүртээмжтэй боловсрол олгох хууль тогтоомж байхгүй байна.

25. Хороо дараах арга хэмжээ авахыг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Тухайн насанд тохирсон сургалтын хөтөлбөрт бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зэрэг жендэрийн зарчмын асуудлуудыг тусгаж, түүнчлэн уг хөтөлбөрт өсвөр насны охид, хөвгүүдэд жендэр ба бэлгийн боловсрол, жендэр ба хариуцлагатай бэлгийн зан үйлийн харилцаа зэрэг асуудлыг багтаах;

(b) Сургууль, дотуур байранд гарч буй бэлгийн дарамт, хүчирхийллийг мөрдөж шалгах, шүүхээр шийдвэрлүүлэхэд багш, суралцагчдын оролцоог

хангах, буруутай этгээдүүдэд зохих ёсны шийтгэл оногдуулах, хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх;

(c) Жирэмсэн охидыг сургуульд нь үргэлжлүүлэн суралцуулах, залуу эхчүүдийг төрснийх нь дараа буцаан нийгэмшүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

(d) Хөгжлийн бэрхшээлтэй охид, тэр дундаа хөдөө орон нутгийн охидыг хамруулсан боловсролын хүртээмжийг хангах, багш нарыг тусгайлсан боловсролын хэрэгцээний сургалтад хамруулахын тулд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.

Хөдөлмөр эрхлэлт

26. Хороо дараах асуудалд анхаарал хандуулж байна. Үүнд:

(a) Бүх салбарт хүйсээрх цалингийн зөрүүтэй байдал нэмэгдэж байгаа, хөдөлмөрийн зах зээл дээр ажил мэргэжлийн хувьд ялгаатай байдал хэвээр байгаа, болон албан ба албан бус салбарт эмэгтэйчүүд ихэвчлэн бага цалинтай ажил хөдөлмөр эрхэлсээр байна;

(b) Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхийг хориглосон ажлын байрны жагсаалт нь хориглох бодитой үндэслэлгүй ажил мэргэжлийг өргөнөөр хамааруулснаар хэт хамгаалалтыг бий болгож, уул уурхайн зэрэг олон салбарт эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийг хязгаарлаж байна;

(c) Хөдөлмөрийн хяналтын тогтолцооны мандат, чадавхи хязгаарлагдмал, төдийлөн үр дүнтэй биш байна;

(d) Эмэгтэйчүүд эрт тэтгэвэрт гарч байгаа нь тэдний хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж, өндөр насны тэтгэврийг нь мөн бууруулахад нөлөөлж байна;

(e) Ажлын байран дахь бэлгийн дарамтыг хориглосон, иргэний болон шийтгэлийн арга хэмжээнүүдийг авах, түүнчлэн гэм буруутай этгээдүүдэд шийтгэл оногдуулах, ял хүлээлгэхтэй холбогдсон мэдээлэл хангалтгүй байна.

27. Хороо дараах зүйлийг Гишүүн оронд зөвлөмж болгож байна. Үүнд:

(a) Улсын болон хувийн салбарт эмэгтэйчүүд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлүүлэхэд ялгаварлах, гадуурхахыг хориглох, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтаар дамжуулан эмэгтэйчүүдийг албан эдийн засагт хөдөлмөр эрхлэхийг дэмжих зэргээр тэднийг эдийн засгийн хувьд бие даасан байдлыг нь дэмжсэн орчныг бүрдүүлэхэд хүчин чармайлтаа нэмэгдүүлэх;

(b) Ижил үнэлэмжтэй ажил хөдөлмөрт адил тэнцүү цалин хөлс олгох, цалин хөлсний зөрүүтэй байдлыг багасгах, арилгах болон эмэгтэйчүүд

ихэвчлэн ажил хөдөлмөр эрхэлж буй салбаруудын цалин хөлсийг нягталж үзэх, хууль тогтоомжийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх;

(c) Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөлийг үр дүнтэйгээр хянадаг, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаа явуулсан ажил олгогчид зохих ёсны шийтгэл оногдуулдаг чанартай бөгөөд чадварлаг хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бий болгох;

(d) Эмэгтэйчүүдийг хориглосон ажил мэргэжлийн жагсаалтыг хянан үзэх, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах замаар урьд өмнө хориглож байсан ажил мэргэжилд эмэгтэйчүүдийг ажиллуулдаг болох;

(e) Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд тэдний тэтгэвэрт гарах насыг эрэгтэйчүүдийнхтэй уялдуулан нэмэгдүүлэх;

(f) Ажлын байран дахь бэлгийн дарамтыг тусгайлан тодорхойлох, хориглох хууль тогтоомжийг батлах.

Эрүүл мэнд

28. Эх, хүүхдийн нас баралтыг бууруулах талаар Гишүүн орны гаргасан ололт амжилтыг Хороо талархан хүлээн авч байгаа хэдий ч дараах асуудалд анхаарал хандуулж байна. Үүнд:

(a) Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, тэр дундаа бэлгийн хариуцлагатай зан үйлийн талаарх цогц мэдлэг, боловсрол олгох явдал хангалтгүй байгаа, түүнчлэн гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ, охид, эмэгтэйчүүдийн дунд жирэмслэлтээс хамгаалах хангагдаагүй хэрэгцээний түвшин өндөр байна;

(b) Эмэгтэйчүүдийн хувьд таагүй хэвшмэл ойлголтыг нэмэгдүүлж, ядууралд хүргэж болзошгүй хүн амын төрөлтийг дэмжсэн бодлого хэрэгжүүлж байна;

(c) Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд болон ЛБТ хүмүүсийн хувьд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдээллийн хүртээмж хангалтгүй байгаа, түүнчлэн эдгээр эмэгтэйчүүдийн тусгайлсан хэрэгцээг хангах эмнэлэгийн ажилтнуудыг сургах асуудал хангалтгүй байна;

(d) Умайн хүзүүний болон хөхний хавдрын тархалтын талаарх мэдээлэл хомс, түүнчлэн охид, эмэгтэйчүүдийн хувьд эмчилгээний хүртээмж хангалтгүй байна;

29. Эмэгтэйчүүд ба эрүүл мэндийн асуудлаарх 24 дүгээр Ерөнхий Зөвлөмжид заасанчлан Хороо дараах зүйлийг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Хүсэзгүй болон эрт үеийн жирэмслэлтийн тохиолдлыг бууруулахын

тулд жирэмслэлтээс хамгаалах хүртээмжтэй, боломжит аргуудын болон гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээллийг өргөнөөр түгээх замаар бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхүүдийн талаар мэдлэг олгох боловсролыг эрчимжүүлэх;

(b) Ядуурлыг бууруулах стратеги баталж, хүүхдээ асарч буй эхчүүдийн аж байдлыг дээшлүүлэх, хүүхэд харах байгууламжуудыг байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр ялгаварлан гадуурхсан хэвшмэл ойлголтыг өөгшүүлсэн төрөлтийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхгүй байх;

(c) Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд болон ЛБТ хүмүүст тэдний эрүүл мэнд, тэр дундаа бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийнх нь талаар мэдээлэл түгээх, тэдний тусгайлсан хэрэгцээг хангах чадавхитай эмнэлгийн боловсон хүчнийг сургах;

(d) Умайн хүзүүний болон хөхний хавдрын тархалттай холбогдсон нарийвчилсан тоо мэдээ цуглуулах, эдгээр өвчнийг эрт үед нь илрүүлэх хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх.

Эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд чадавхжуулах

30. Хороо эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломж болон манлайллыг дэмжих дэд стратегийг 2014 онд баталсныг онцлон тэмдэглэж байна. Гэвч эмэгтэйчүүдийн дунд, ялангуяа хөдөө орон нутагт болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн дунд ядуурал өндөр хэвээр байгаа, түүнчлэн өмч, санхүүгийн зээл, барьцааны хүртээмж эмэгтэйчүүдийн хувьд хангалтгүй байгаад Хороо сэтгэл зовниж байна. Түүнчлэн, ахмад настай болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хөгжлийн төслүүдийг хэлэлцэж, шийдвэр гаргах түвшинд оролцох, хэрэгжилтээс нь ашиг тус хүртэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээнүүдийг хангалттай авч хэрэгжүүлэхгүй байгаад сэтгэл зовниж байна.

31. Хороо нь хөдөө орон нутгийн, өрх толгойлсон, ахмад настай болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн нэгэн адил хүртээмжээр хангах замаар ядуурлаас гаргах, эдийн засгийн хувьд эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Хөдөөгийн эмэгтэйчүүд

32. Хороо дараах зүйлд анхаарал хандуулж байна. Үүнд:

(a) Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн нөхцөл байдал эмзэг байгаа болон тэдний нөхцөл байдлын талаарх тоо мэдээ хангалтгүй байгаа, ядуурлыг шийдвэрлэх, газар эзэмших, ашиглах боломжийг хангах талаар

Гишүүн орны авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй байгаа, түүнчлэн шүүх, боловсрол, эрүүл мэнд, орон сууц, ундны ус, ариун цэвэр хангагдах, албан ёсны хөдөлмөр эрхлэх, ур чадварыг хөгжүүлэх, сурах боломж, орлого нэмэгдүүлэх боломж ба зээл хүртэх зэрэг хүртээмж хангалтгүй байгааг тэмдэглэж байна.

(b) Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцад хөдөөгийн эмэгтэйчүүдийн оролцоо доогуур байна;

(c) Цаг уурын өөрчлөлт болон байгалийн эрсдлийн үр нөлөө, аж үйлдвэр, ялангуяа уул уурхайн салбарын байгаль орчин дахь сөрөг үр дагавар нь Гишүүн орны хөдөөгийн эмэгтэйчүүдэд харьцангуй сөргөөр нөлөөлж байна.

33. Хороо дараах зүйлийг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Хөдөө орон нутагт дэд бүтцийг сайжруулах, эмэгтэйчүүдийн тусгайлсан хэрэгцээнд нийцүүлэн шүүх, боловсрол, орон сууц, найдвартай ундны ус, ариун цэвэр, албан ёсны хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг нь дадлагажуулах, хөгжүүлэх сургалтад хамруулах, орлого олох, жижиг зээл хүртэх боломж болон газар өмчлөх, ашиглах боломжийг бүрдүүлж, хөдөөгийн эмэгтэйчүүдийн ядуурлыг арилгах бодлого боловсруулах чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа, дэмжлэг эрэлхийлэх;

(b) Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн нэгэн адил оролцуулах;

(c) Хөдөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратеги нь эмэгтэйчүүдийн хүний эрхэд үзүүлж буй үр нөлөөг судлах, хөдөөгийн эмэгтэйчүүдийн талаар нарийвчилсан тоо мэдээ цуглуулах;

(d) Жендэрийн асуудлыг цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, эрсдлийг бууруулах, түүнчлэн уул уурхайн зэрэг аж үйлдвэрийн салбарын байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн үндэсний бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах, ингэхдээ эмэгтэйчүүдийг хохирогч гэж үзэхээс илүүтэй тэдгээрийн боловсруулалтад идэвхтэй оролцоог нь хангана.

Хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай эмэгтэйчүүд

34. Хороо хүртээмжтэй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг нь хамгаалах төрийн бодлого, арга хэмжээ дутагдалтай байгаа, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, дарамтаас хамгаалах механизм үгүйлэгдэж байна. Түүнчлэн, ахмад настай эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, тэд хүчирхийллээс хамгаалагдах, тэдний хувьд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаад анхаарал

хандуулж байна.

35. Хороо дараах арга хэмжээ авахыг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн хувьд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад үндсэн үйлчилгээ, нийгмийн хамгааллын тэгш хүртээмжийг бүрдүүлэх, тэдний бие даах нөхцөлийг хангаж, бүх нийтийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, улс төр, нийгмийн амьдрал дахь оролцох эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг батлах;

(b) Хөдөө, алслагдсан орон нутагт байгаа, хөгжлийн бэрхшээл, нас, бусад хүчин зүйлс, түүнчлэн алс тусгаарлагдмал болон хязгаарлагдмал байдал болон бие махбодын ба сэтгэл зүйн янз бүрийн хүчин зүйлийн улмаас давхардсан ялгаварлан гадуурхалттай тулгарч буй хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай эмэгтэйчүүдийг олж тогтоох чиглэлээр иргэний нийгмийн, нийгэм хамт олонд тулгуурласан болон олон улсын бусад байгууллагуудтай хамтын ажиллагааны түншлэлийг хөгжүүлэх.

Гэрлэлт ба гэр бүлийн харилцаа

36. Хороо ганц бие эх, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, ялангуяа ядуурал, ялгаварлан гадуурхалт, дарамтад илүүтэй өртөж болзошгүй ганц бие эхчүүд, тэдний хүүхүүдийн тэтгэмж доогуур байгаа болон дэмжих хөтөлбөрүүд дутагдалтай байгаад сэтгэл зовниж байна.

37. Хороо дараах зүйлийг Гишүүн оронд зөвлөж байна. Үүнд:

(a) Ганц бие эхчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, тэдний хүүхүүдийн амьдралын зохистой нөхцөлийг хангах зорилгоор тэдэнд олгож буй гэр бүлийн тэтгэмжүүдийн хэмжээг тогтмол эргэн авч үзэж, нэмэгдүүлж, өөрчлөлт оруулж байх;

(b) Ганц бие эхчүүдийг эдийн засгийн хувьд чадавхжуулах, тэднийг зохистой орон сууц, боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн асаргаа үйлчилгээ, соёлын амьдралын хүртээмжийг хангах, ялгаварлан гадуурхалт, дарамтаас хамгаалахад чиглэсэн зорилтот арга хэмжээ, хөтөлбөрүүдийг баталж хэрэгжүүлэх.

Мэдээлэл цуглуулах

38. Хороо нь эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа эсэхийг тогтоох, мэдээлэлд суурилсан зорилтот бодлого боловсруулах болон энэхүү Конвенцийн хамарч буй бүхий л хүрээнд эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах чиглэлээр гарч буй аливаа хөгжил дэвшилд тогтмол хяналт, шинжилгээ хийх зорилгоор тэдний нөхцөл байдалд сайтар үнэлгээ хийхэд

шаардлагатай хүйс, нас, хөгжлийн бэрхшээл, яс үндэс, газарзүйн байршил болон нийгэм, эдийн засгийн байдал зэргийн задаргаатай тоо мэдээ ерөнхийдөө хангалтгүй байгаад анхаарал хандуулахыг хүсч байна.

39. Хороо нь жендэрийн тэгш байдлыг бодлого, үйл ажиллагаанд тусгах, эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийн үр нөлөө, үр дүнтэй байдалд үнэлгээ, дүгнэлт хийхэд шаардлагатай, хүйс болон бусад хүчин зүйлсийн задаргаатай тоо мэдээ цуглуулахын тулд жендэрийн үзүүлэлтийн системийг хөгжүүлэхийг Гишүүн оронд уриалж байна. Иймд, Хороо эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаарх статистик тоо мэдээллийн тухай 1989 оны 9 дүгээр Ерөнхий Зөвлөмжид анхаарал хандуулахыг Гишүүн оронд зөвлөж, нямбай тоо мэдээ цуглуулдаг болоход холбогдох НҮБ, эмэгтэйчүүдийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа дээшлүүлэхийг хөхиүлэн дэмжиж байна.

Бээжингийн Тунхаглал болон Үйл ажиллагааны Хөтөлбөр

40. Хороо нь уг Конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэхдээ Бээжингийн Тунхаглал болон Үйл ажиллагааны Хөтөлбөрийг ашиглахыг Гишүүн оронд уриалж байна.

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн төлөвлөгөө

41. Хороо нь Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх зорилтуудыг хэрэгжүүлэхдээ уг Конвенцийн заалтуудад нийцүүлэн жендэрийн тэгш байдлыг бодитойгоор хэрэгжүүлэхийг Гишүүн оронд уриалж байна.

Мэдээлэл түгээх

42. Хороо нь энэхүү Конвенцийн заалтуудыг системтэйгээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг Гишүүн оронд уриалж байна. Иймд Хороо энэхүү дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн албан ёсны хэл дээр Засгийн газар, яамд, УИХ, шүүхийн байгууллага зэрэг төв, бүс нутгийн болон орон нутгийн бүхий л холбогдох байгууллагуудад түгээхийг Гишүүн оронд зөвлөж байна. Хороо Гишүүн орныг ажил олгогчдын төлөөллийн байгууллага, үйлдвэрчний эвлэл, хүний эрхийн, эмэгтэйчүүдийн байгууллагууд, судалгааны институтууд, их, дээд сургуулиуд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллахыг уриалж байна. Түүнчлэн, энэхүү Дүгнэлтийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхийн тулд зохистой хэлбэрээр түгээхийг зөвлөж байна. Улмаар, Хороо энэхүү Конвенц, түүний Нэмэлт Протокол, холбогдох баримт бичгүүдийг болон Хорооны Ерөнхий Зөвлөмжүүдийг холбогдох бүхий л талуудад түгээх хүсэлтийг Гишүүн оронд тавьж байна.

Техникийн туслалцаа

43. Хороо дээр дурдсан зөвлөмжүүдийг болон энэхүү Конвенцийг бүхэлд нь хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд олон улсын дэмжлэг, техникийн туслалцаа авах талаар эрэлхийлж ажиллахыг Гишүүн оронд зөвлөж байна. Түүнчлэн, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг Гишүүн оронд зөвлөж байна.

Бусад гэрээнүүдийг соёрхон батлах

44. Хороо эмэгтэйчүүдийн хүний эрх, суурь эрх чөлөөгөө эдлэх явдлыг сайжруулахад чиглэсэн олон улсын хүний эрхийн 9 баримт бичгийг дагаж мөрдөж ажиллахыг тэмдэглэж хэлэхийг хүсч байна. Иймд Гишүүн орны хараахан нэгдэн ороогүй байгаа Бүх Цагаач ажилчид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийн тухай Конвенцийг соёрхон батлах асуудлыг авч үзэхийг Гишүүн оронд уриалж байна.

Ажиглалтын дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ

45. Хороо дээр дурдсан параграф 17 (a), 19 (a), (b), (e)-д өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг 2 жилийн дотор ирүүлэхийг Гишүүн оронд зөвлөж байна.

Дараагийн ээлжит илтгэл бэлтгэх

46. Хороо дараагийн ээлжит 10 дугаар илтгэлээ 2020 оны 3 дугаар сард ирүүлэх хүсэлтийг Гишүүн оронд тавьж байна.

47. Хороо ‘Common core document болон гэрээтэй холбогдолтой бусад баримт бичгүүд зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдийг тайлагнах нэгдсэн удирдамж (HRI/MC/2006/3 and Corr.1)-ийг мөрдлөг болгохыг Гишүүн оронд санал болгож байна.